

МОНГОЛ УЛС ДАХЬ ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН  
НӨХЦӨЛ БАЙДАЛ: ЦААШДЫН ЧИГЛЭЛ

# Англи хэлнээс орчуулав

Авлигыг бууруулахад ил тод байдлыг хангах нь тайланг бэлтгэсэн:

Майкл Баррон

Тим Лоу

Жейк Хартнетт

Ц.Батсугар

А.Амарсанаа

Ж.Ариунцэцэг

## “АВЛИГЫГ БУУРУУЛАХАД ИЛ ТОД БАЙДЛЫГ ХАНГАХ НЬ” ТӨСЛИЙН ТУХАЙ

“Авлигыг бууруулахад ил тод байдлыг хангах” (LTRC) төсөл нь Брүүкингс институтын Засаглалын судалгааны хөтөлбөр болон Хөгжлийн төлөөх судалгаа (R4D) хөтөлбөрийн Хариуцлага, иргэдийн оролцооны төслийн удирдан хэрэгжүүлж буй олон улсын ажиллагаа-судалгаа хосолсон санаачлага юм. Хөгжлийн төлөөх судалгаа (R4D) нь байгалийн баялагтай холбогдсон үйл ажиллагааны гинжин хэлхээнд үүсэх авлигыг бууруулах чиглэлээр ил тод байдал, олон талын оролцоо ба газар дээрх үнэлгээ гэсэн гурван хүчин зүйлийг (TAP) шингээсэн стратеги төлөвлөгөө, интервенци тодорхойлох, хамтран боловсруулах, олон нийтэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг. LTRC-ын үндсэн зорилтууд нь байгалийн баялгийн засаглал дахь авлигын эрсдэлийг бууруулах хамгийн үр дүнтэй арга барилын талаарх талуудын мэдлэг, ойлголтыг дээшлүүлэх, болон авлигыг бууруулж, урьдчилан сэргийлэх замаар тогтвортой хөгжлийг хангах юм.



LTRC төсөл нь улс орон болон олон улсын түвшинд олборлох салбарт сайн засаглалыг бий болгох, авлигатай тэмцэх чиглэлээр ажиллаж буй төрөл бүрийн талуудад судалгаа хийх, мэдлэг хуваалцах, шинэ туршлага нэвтрүүлэх замаар дэмжлэг үзүүлдэг. Бидний мөрдлөг болгодог байгалийн баялгийн өртгийн сүлжээ дэх авлигатай тэмцэх (TAP-Plus) баримт бичгийн гол зарчим нь байгалийн баялгийн засаглал дахь авлигын уг үндсийг арилгахын тулд талуудын хооронд үр дүнтэй хэлэлцээр өрнүүлэх нөхцөлийг бүрдүүлэх юм.

## БРҮҮКИНГС ИНТИТУТЫН ТУХАЙ

Брүүкингс институт нь бие даасан судалгаа, бодлогын шийдлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг ашгийн бус байгууллага юм. Тус байгууллагын эрхэм зорилго нь өндөр чанартай, хараат бус судалгааг хийж, тэрхүү судалгааны үр дүнгээ бодлого боловсруулагч нар болон олон нийтэд танилцуулан, шинэлэг, бодит саналыг гаргах явдал юм. Брүүкингс Институтын гаргасан товхимолууд дахь аливаа дүгнэлт, санал нь тухайн баримт бичгийг боловсруулагч нарын үзэл бодлыг шингээсэн бөгөөд тус байгууллага болон түүний удирдлага, бусад судлаач нарын байр суурийг илэрхийлдэггүй болно.

Энэхүү судалгааг ВНР Сангаас голлон санхүүжүүлсэн ба тайланд тусгасан дүгнэлт, тайлбар нь судлаач нарын байр суурийг илэрхийлэх бөгөөд ВНР Сан болон бусад санхүүжүүлэгч талын байр суурийг илтгэх албагүй болно. Тайлангийн зорилго нь чанар, хараат бус байдал, эерэг нөлөөллийг авчрах Брүүкингс Институтын зорилготой уялдаж байна. Түүнчлэн, санхүүжүүлэгч талын үйл ажиллагаа ч энэхүү зорилгод чиглэдэг.

## ХӨГЖЛИЙН ТӨЛӨӨХ СУДАЛГАА (R4D) ХӨТӨЛБӨРИЙН ТУХАЙ

Хөгжлийн төлөөх судалгаа (R4D) нь хөгжлийн төлөөх үйл ажиллагааг олон улсад хамтран хэрэгжүүлэгч ашгийн бус түншлэгч юм. R4D нь дэлхий дахинаа боловсролтой, эрүүл иргэдийг дэмжигч чадварлаг тогтолцоог бий болгохын тулд засгийн газрууд, иргэний нийгэм, инновац хөгжүүлэгчидтэй хамтран ажилладаг. Ингэхдээ эрүүл мэнд, боловсрол, хоол тэжээлийн чиглэлээр мэргэшсэн экспертүүдийг судалгаа шинжилгээ, болон бусад төрлийн дэмжлэгээр ханган шийдвэр гаргалт, тэдгээрийн хэрэгжилтийг хангах болон асуудал шийдэх харилцаа холбоо үүсгэх боломжийг бүрдүүлдэг.



## ТАЛАРХАЛ

LTRC -ын зүгээс энэхүү тайланг бэлтгэсэн Майкл Баррон консалтинггаар удирдуулсан баг болон англи тайланг хянан тохиолдуулсан Хууль тогтоомж, бодлого судалгааны төвийн Д. Тэгшбаяр, Global Integrity байгууллагын Жорже Флорез нарт гүнээ талархаж байна.

# Агуулга

---

i. Оршил	2
ii. Товчилсон үгс	4
1. Танилцуулга	5
1.1 Зорилтууд	6
1.2 Хамрах хүрээ	7
1.3 Арга зүй	7
2. Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал	8
2.1 Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтын харьцуулалт	9
2.2 ФАТФ-ын Харилцан үнэлгээний үр дагавар	10
2.3 Монгол дахь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга	11
2.4 Компани, аж ахуйн нэгжийн бүртгэлийн үйл явц	12
2.5 Төрийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлэг	13
3. Эцсийн өмчлөгчийн чиглэлээрх олон улсын стандартууд	15
3.1 ОУИТБС-ын шаардлагууд	15
3.2 Санхүүгийн үйл ажиллагааны ажлын хэсгийн (ФАТФ) шаардлагууд	16
3.3 Олон улсын сайн туршлагууд	17
4. Оролцогч талуудын зураглал, оролцоо	21
4.1 Оролцогч талууд, оролцооны ирээдүйн зураглал	22
5. Хийдлийн шинжилгээ (Gap analysis)	23
6. Зөвлөмжүүд	25
7. Хавсралтууд	27
Хавсралт 1: Оролцогч талуудтай хийсэн ярилцлага, асуулга	27
Хавсралт 2: Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтын жишээ	29
Хавсралт 3: Улс төрд нөлөө бүхий этгээдийн тодорхойлолтын жишээ	29
Хавсралт 4: Баталгаажуулалтын стратегийн арга хандлага	30
8. Номзүй	31

# Оршил

Хөгжлийн төлөөх судалгаа (R4D) хөтөлбөрийн хэрэгжүүлж буй “Авлигыг бууруулахад ил тод байдлыг хангах” төслийн (LTRC) хүрээнд Монгол Улсын уул уурхайн салбарын эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлын өнөөгийн нөхцөл болон цаашид хэрэгжүүлэх ажлын саналыг тусгасан энэхүү тайланг бэлтгэн толилуулж байна. Уг тайлан нь Монгол Улсад эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох үр дүнтэй экосистем бүрдүүлэхийн тулд оролцогч талуудтай хамтран тодорхойлсон өргөн хүрээний асуудлыг тусгасан хэд хэдэн цуврал баримт бичгийн түүхээ нь юм. Эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр өдгөө хэрэгжүүлж буй үйл явцыг улам сайжруулахын тулд LTRC төсөл нь 2020 оны 11 сард Монголын иргэний нийгэм, төрийн болон олон улсын байгууллагын төлөөлөл оролцсон цахим дугуй ширээний хэлэлцүүлэг өрнүүлж, үйл ажиллагаагаа албан ёсоор эхэлсэн билээ. Уг арга хэмжээний үеэр бидний хэрэгжүүлэх судалгааны гол чиглэл томъёологдон гарсан бөгөөд эдгээрт эцсийн өмчлөгчийн асуудлыг зохицуулах хууль тогтоомж, мэдээллийн санд өгөгдөл цуглуулах ажиллагаа зэрэг орсон бөгөөд улмаар энэхүү тайлангийн гол сэдэв болж байна.

## СУДАЛГААНЫ ГОЛ ҮР ДҮНГ ДУРДВАЛ:

- Хуулийн этгээд бүр өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт (УБЕГ) бүртгүүлэх тухай хуульд заасан шаардлагын хэрэгжилт Монгол улсын хувьд эхлэлийн шатандаа явж байна. 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдөр буюу эцсийн өмчлөгчийн мэдээллээ улсын бүртгэлд бүртгүүлэх сүүлийн хугацаанд багтаж ойролцоогоор 30,000 аж ахуйн нэгж тайлангаа хүргүүлсэн ажээ<sup>1</sup>.
- Хуулийн этгээдийн талаарх ерөнхий мэдээлэл олон нийтэд нээлттэй боловч эцсийн өмчлөгчийн тухай мэдээлэл харахан ил тод болоогүй байна. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл нь УИХ-ын чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад багтсан бөгөөд энэ жилийн эцсээр батлагдан хүчин төгөлдөр болох төлөвтэй байна. Уг нэмэлт өөрчлөлтөөр олон нийт эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг олж авах эрх зүйн үндэс бүрдэх юм.
- Эцсийн өмчлөгчийн мэдээлэлд олон нийт хандах боломж бүрдсэнээр эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг ил тод болгох чиглэлд нэгэн чухал ахиц бий болж буй явдал юм. Гэвч эцсийн өмчлөгчийн тухай мэдээллийг бүртгэж олон нийтэд хүртээлтэй болгоход учрах олон саад бэрхшээл байгаагийн заримаас дурдвал шаардлагатай мэдээлэл тэр болгон цахимжаагүй болон эцсийн өмчлөгчийн мэдээллийн санг бий болгох шаардлага зэрэг болно. УБЕГ мэдээллийг цахим хэлбэрт шилжүүлж эхэлсэн бөгөөд E-Mongolia хөтөлбөрийн хүрээнд төрийн үйлчилгээ улам илүү өргөн хүрээнд хурдацтай цахимжих төлөвтэй байна.
- Монгол улс ФАТФ-ын “өндөр хяналт шаардлагатай улс”-ын жагсаалт (албан бус хэллэгээр “саарал жагсаалт”) аас гарснаас хойш эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох ажил удааширч саарсан дүр зураг ажиглагдаж байна. Түүнчлэн, бидэнтэй ярилцлага өгсөн хэд хэдэн хүний зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох чиглэлээр манлайлал дутагдаж байгааг цохон тэмдэглэж байлаа.
- Авлигатай тэмцэх газар (АТГ)-ын Нийтийн албан тушаалтны хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хэрэгжилт сайтай байна. Хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл болон УБЕГ-ын эцсийн өмчлөгчийн бүртгэл нь хоорондоо уялдаатай бөгөөд энэ хоёр бүртгэлийн харилцан уялдаа сайн байх нь эргээд дэх мэдээллийг баталгаажуулахад чухал үүрэг гүйцэтгэх юм.

<sup>1</sup> 2019 оны байдлаар Монгол улсад 198,000 хуулийн этгээд бүртгэгдсэн байгаагаас хэд нь идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан талаарх мэдээлэл олдсонгүй. Харин 2021 онд 205,000 хуулийн этгээд бүртгэлтэй байгаагийн 45 хувь нь идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг байна. 2019 онд идэвхтэй үйл ажиллагаа явуулж байсан байгууллагын тоог 2021 оны хувьтай ойролцоо гэж үзвэл 2020 оны эцэст нийт идэвхтэй үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээдийн гуравны нэг нь эцсийн өмчлөгчийн мэдээллээ тайлагнасан байна. Эх сурвалж: <https://montsame.mn/mn/read/260726>.

## ЭНЭХҮҮ ТАЙЛАНД НИЙТ 10 САНАЛ ЗӨВЛӨМЖИЙГ ТОДОРХОЙЛОН ГАРГАСАН БА ЭДГЭЭР НЬ:

- 1. Манлайлагч тодорхойлох:** Эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох ажлыг удирдан жолоодох нэр хүндтэй, олны итгэлийг хүлээсэн манлайлагчтай болох нь зүйтэй. Энэхүү манлайлагчийг засгийн газар, УИХ, иргэний нийгмийн байгууллага, бизнесийн салбараас тодруулж болох бөгөөд гагцхүү олны дэмжлэгийг хүлээж, нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн манлайлагч байх нь чухал.
- 2. Техникийн туслалцаа үзүүлэх дэмжлэг, санхүүжилтийг олох:** УБЕГ-т Эцсийн өмчлөгчийг бүртгэх, мэдээлэл цуглуулах ажлыг цахимжуулахад нь техникийн туслалцаа үзүүлж, санхүүжүүлэх боломжтой олон улсын байгууллагуудыг тодорхойлох хэрэгтэй байна. Монгол улсын Засгийн газраас энэ төрлийн тусламж, дэмжлэг үзүүлэх хүсэлтийг холбогдох талуудад тавих нь зүйтэй. Эдгээрийн заримаас дурдвал олон улсын хөгжлийн банкууд (АХБ, ЕСБХБ г.м.), олон улсын байгууллагууд (ЕХ гэм мэт), хоёр талын хандивлагч улс орнууд дангаараа болон хамтран техникийн туслалцаа үзүүлэх боломжтой юм.
- 3. Олон-талт/агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах:** Олон нийтэд нээлттэй хэлбэр бүхий эцсийн өмчлөгчийн мэдээллийг санг бүрдүүлэх зорилгоор Засгийн газраас Ажлын Хэсэг байгуулах нь зүйтэй. Энэхүү Ажлын хэсэгт бүртгэлийн систем хөгжүүлэх, ажиллуулах, хэрэгжүүлэх, ашиглах чиг үүрэгт хамаарах төрийн байгууллагын бүх төлөөлөл оролцох ёстой.
- 4. Иргэний нийгмийн байгууллагын хяналтыг бий болгох:** Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухайн хуулийн нэмэлт өөрчлөлт оруулах үйл явц, эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр хэрэгжилтэд мониторинг хийж, эерэг нөлөөлөл гарч буйг баталгаажуулах шаардлагатай.
- 5. Тодорхойлолтыг нэг болгох:** Монгол улсын Засгийн газрын зүгээс эцсийн өмчлөгчийн тухай олон тодорхойлолтоос нэгийг нь сонгон цаашид жигд хэрэглэж хэвших шаардлагатай байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан тодорхойлолтыг УБЕГ эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэхэд ашиглаж буй тул энэхүү тодорхойлолтыг сонгон цаашид нэг мөр хэрэглэж болох юм.
- 6. Эцсийн өмчлөгчийг тайлагнах болон редакц хийх шаардлагыг тодорхой болгох:** Эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг хуульчлахын зэрэгцээ Монгол улсын Засгийн газрын зүгээс хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, төрийн өмчит компаниуд болон гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээдэд эцсийн өмчлөгчөө тайлагнах тусгайлсан шаардлагыг тавих хэрэгтэй.
- 7. Бүртгэлийн уялдааг хангах:** АТГ болон УБЕГ нь нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл болон эцсийн өмчлөгчийн бүртгэлийг харилцан уялдуулах чиглэлээр бодлогын түвшинд хамтран ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл энэхүү хоёр байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийг харилцан солилцож, баталгаажуулснаар үйл ажиллагааны үр ашиг болон мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдэнэ.
- 8. Хянан баталгаажуулах стратегийг хэрэгжүүлэх:** УБЕГ нь өөрт цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хянан баталгаажуулах чиглэлээр стратеги боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай.
- 9. Хөрөнгө орлогын мэдүүлэгт буй мэдээллийг хянан баталгаажуулах:** АТГ нь нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэгт буй мэдээллийн үнэн зөв байдлыг хянан баталгаажуулах чиглэлээр стратеги хэрэгжүүлэх шаардлагатай.
- 10. Стратегийн мэдээлэл харилцааны кампанит ажил хэрэгжүүлэх:** УБЕГ нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл, үүнийг олон нийтэд ил болгохын давуу талуудыг онцолсон стратегийн мэдээлэл харилцааны кампанит ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх шаардлагатай.

Энэхүү судалгааг 2021 оны 3 дугаар сарын 24-нөөс 4 дүгээр сарын 30-ны өдрүүдэд Майкл Баррон болон Тим Лоу нараар удирдуулсан олон улсын болон дотоодын зөвлөхүүдийн хамтарсан баг хийж гүйцэтгэв.

Тус тайлан нь Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) 2019 оны стандартын дагуу эцсийн өмчлөгчийн мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээсэн Монгол улсын уул уурхайн салбарын аж ахуйн нэгжүүд эцсийн өмчлөгчийн мэдээллээ тайлагнасан байдалд төвлөрөн боловсруулагдсан болно.

Судалгааг холбогдогч талуудтай ярилцлага хийх болон шаардлагатай бичиг баримттай танилцах замаар гүйцэтгэж эцсийн өмчлөгчийн талаарх хууль эрх зүйн орчин, мэдээллийн хүртээмж, нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн мэдээллийн системд тус тус үнэлгээ өгсөн. Баримт бичгийн судалгааны хүрээнд Монгол улсын холбогдох хууль тогтоомжууд, бусад гол баримт бичгүүдийг нарийвчлан судлав. Түүнчлэн, бид судалгаандаа Монгол болон бусад улс орны сайн туршлагыг тусгасан болно.

## Товчилсон үгс

---

<b>МУТ</b>	Мөнгө угаахтай тэмцэх
<b>МУТСТХ</b>	Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013
<b>ЭӨ</b>	Эцсийн өмчлөгч
<b>ЭБИТБ</b>	Эцсийн өмчлөгчийн ил тод байдал
<b>ТСТ</b>	Терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх
<b>ОУИТБС</b>	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
<b>МОУИТБС</b>	Монголын Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга
<b>ОУИТБТХ</b>	Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл (Уул уурхайн ил тод байдлын тухай хууль)
<b>ФАТФ</b>	Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын байгууллага
<b>УБЕГ</b>	Улсын бүртгэлийн ерөнхий газар
<b>ДНБ</b>	Дотоодын нийт бүтээгдэхүүн
<b>ТЕХ</b>	Татварын ерөнхий хууль
<b>МУЗГ</b>	Монгол улсын Засгийн газар
<b>АТГ</b>	Авлигатай тэмцэх газар
<b>ҮД5</b>	ФАТФ Үр дүн 5
<b>LTRC</b>	“Авлигыг бууруулахад ил тод байдлыг хангах” төсөл
<b>ОТОБ</b>	Олон талын оролцоот бүлэг (ОУИТБС)
<b>УТНБЭ</b>	Улс төрд нөлөө бүхий этгээд
<b>324</b>	ФАТФ Зөвлөмж 24
<b>R4D</b>	Хөгжлийн төлөөх судалгаа
<b>ХЭУБТХ</b>	Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018
<b>ТТ</b>	Техникийн туслалцаа

# 1. Танилцуулга

---

Эцсийн өмчлөгчийн ил тод байдал нь олборлох салбарын шударга байдалд иргэд, төр засаг, салбарын оролцогч талууд болон санхүүжүүлэгчид итгэх итгэлийг бий болгоод зогсохгүй бүхий л эдийн засагт чухал ач холбогдолтой билээ. Олон улсын хөрөнгө оруулагчид, зээлдүүлэгчдийн зүгээс ил тод байдлыг сайжруулах чиглэлээр тавьж буй шаардлага улам бүр өсөн нэмэгдсээр байна. Үүний зэрэгцээ улс орнуудын Засгийн газрууд итгэлцэл бий болгох, авлига, мөнгө угаалт болон татвараас зайлсхийх явдлыг бууруулах арга замыг түлхүү хайж эхэлсний улмаас компаниудын эцсийн жинхэнэ эздэд дэлхий нийтээр түлхүү анхаарал хандуулах болжээ. Үүний улмаас бодлого боловсруулагчдын зүгээс эцсийн өмчлөгчийг ил тод болгох асуудлыг өөрийн мөрийн хөтөлбөрт тусгах явдал нийтлэг болж байна. Монгол улс нь уул уурхайн салбартаа хөрөнгө оруулалт, санхүүжилт татах хүчин чармайлтаа үргэлжлүүлэхийн хэрээр ил тод байдлын шаардлагуудыг өргөн хүрээнд хангах, нэн ялангуяа олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдийн эцсийн өмчлөгчийг ил болгох хүлээлтэд нийцэх шаардлага үүсэн гарч байна. Гадаадын хөрөнгө оруулалт, санхүүжилт татахын тулд улс орнууд хоорондоо ширүүн өрсөлдөж ирсэн бөгөөд ил тод байдлыг илүүтэй хангасан улс орнууд л хөрөнгө оруулалтын чиглэлээр амжилтад хүрэх нь дамжиггүй. Энэ өрсөлдөөн Ковид цар тахлын дараах нөхцөл байдалд улам ч их тод томруун болох тул ил тод байдлыг хангах нь юу юунаас чухал.

Эцсийн өмчлөгч гэдэг нь хуулийн этгээд эсвэл бизнесийн үйл ажиллагааны эцсийн үр шимийг хүртэж, санхүүгийн өгөөж авч буй хувь хүнийг хэлнэ. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаарх олон улсад нэгдсэн стандарт байхгүй ч энэ талаарх олон улсын ерөнхий нөхцөл байдал, хандлагыг 3 дугаар хэсэгт орууллаа. Эцсийн өмчлөгчийг ил тод тайлагнах чиглэлээр бодлогын олон сонголтууд байдаг ба бидний судалгаа нь Монгол улсын эрх зүйн орчин, мэдээллийн хангамжид хамгийн хамааралтай гэсэн хэсгийг хамарсан.

Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангаснаар олборлох салбарын олж буй орлогоос хэн үр өгөөж хүртэж буй, салбарын компаниудыг хэн хяналтдаа байлгаж байгааг сонирхогч талууд олж мэдэх боломжийг олгоно. Энэ нь засаглал, эгэх хариуцлагыг сайжруулж өгдөг. Эцсийн өмчлөгчийн ил тод байдал нь олборлох үйлдвэрлэлийг салбарын жинхэнэ ашиг хүртэгчид хаалттай халхавч компанийн ард нуугдах эсвэл компанийн, эрх зүйн ээдрээт бүтцийг ашиглан дараах үйлдлийг хийхээс сэргийлдэг:

- Орлогоо тайлагнахаас зайлсхийх;
- Татвараас зайлсхийх;
- Ашиг сонирхлын зөрчлөө нуун далдлах; болон
- Мөнгө угаах, авлига хээл хахууль болон терроризм гэх мэт гэмт үйлдэлд холбогдох.

Эцсийн өмчлөгчийг ил тод болгосноор олборлох үйлдвэрлэлд хэн хөрөнгө оруулалт хийж буй, эдгээр нь улс төрд нөлөө бүхий этгээдтэй ямар нэгэн холбоо хамаарал буй эсэхийг тодорхой харуулдаг. Олон улс орон, үүний дотор Монгол улс мөнгө угаахтай тэмцэх хуульдаа эцсийн өмчлөгчийг талаарх үзэл баримтлалыг тусган өгсөн байдаг. Олборлох салбарт үйл ажиллагаа явуулж буй компаниудын эцсийн өмчлөгчийг олон нийтэд ил тод болгох нь чухал ач холбогдолтой бөгөөд ингэснээр салбарын засаглал, хариуцлагатай байдлыг сайжруулдаг.

Энэхүү тайланд дараах чиглэлд хийсэн судалгааны үр дүнг тусгасан:

- Монгол улсад эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээрх эрх зүйн орчин,
- Эцсийн өмчлөгчийн талаарх үнэн зөв мэдээллийн хангамж,
- Нийтийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийн бүртгэл.

Олон улсын болон Монгол улсын экспертүүдийн хамтарсан баг энэхүү судалгааг 2021 оны 3 дугаар сарын 24-нөөс 4 дүгээр сарын 30-ны өдрүүдэд хийж гүйцэтгэв. Судалгаанд ашигласан арга зүйн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доор орууллаа.

Уг тайлан дараах хэсгээс бүрдэнэ:

- Эцсийн өмчлөгч болон нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэлийн талаарх Монгол улсын өнөөгийн нөхцөл байдлын үнэлгээ;
- Эцсийн өмчлөгчийн чиглэлээрх олон улсын стандарт, туршлага;
- Оролцогч талуудын зураглал, оролцоо;
- Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын сайн туршлагыг харьцуулсан хийдлийн (Gap) шинжилгээ; болон
- Хийж хэрэгжүүлэх арга хэмжээний санал зөвлөмж.

Эцсийн өмчлөгчийн ил тод байдал өнөөг хүртэл үзэл баримтлалын хувьд хувьсан өөрчлөгдсөөр байна. Энэхүү тайланд эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаар Монгол улс болон олон улсын арга хандлагын талаар тайлангийн багийн судалгаа хийгдсэн цаг үе дэх ойлголтыг тусгасан ба энэ чиглэлээр цаашид Монголын болон олон улсын хамтрагч талуудын дунд хэлэлцүүлэг өрнүүлэх зорилготой боловсруулагдсан болно.

## 1.1 ЗОРИЛТУУД

Тус тайлан нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах, хадгалах, хянан баталгаажуулах, олон нийтэд ил тод болгох чиглэлийн үйл ажиллагаанд зориулсан тодорхой зөвлөмжүүдийг агуулсан ба хууль эрх зүйн орчин болон бүрдүүлэх чиглэлд түлхүү суурилан боловсруулагдсан болно.

Энэхүү тайланд дараах зүйлсийг онцгойлон тусгасан:

1. Олборлох салбар болон нийт эдийн засгийн салбарт үйл ажиллагаа явуулагч хуулийн этгээдүүдийн хувьд эцсийн өмчлөгч гэж хэнийг хэлэх талаарх нэгдсэн суурь тодорхойлолтын саналаа тусгасан бөгөөд үүнийг Монгол улсын холбогдох хууль тогтоомжид тусгах боломжтой. Уг санал нь Монгол улсад энэ чиглэлээр хийгдсэн ажиллагаа болон олон улсын сайн туршлагыг тус тус харгалзан үзсэн. Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтыг гаргахдаа “жинхэнэ эзэмшигч”, “эцсийн шийдвэрийг гаргагч”, “дийлэнх хувь эзэмшигч” зэрэг нэр томъёо болон “шууд бусад хяналт” зэрэг ойлголтыг тус тус багтаасан байна. Түүнчлэн, улс төрд нөлөө бүхий этгээд, тэдгээрийн гэр бүлийн гишүүн, хамааралтай этгээд болон улс төрд нөлөө бүхий этгээд хэмээн тооцогдох хугацаа зэргийг мөн хамруулан боловсруулсан.
2. Хувь хүнийг эцсийн өмчлөгч хэмээн тооцох өмчлөлийн босго хувийн талаарх саналыг олон улсын сайн туршлага, бусад улс орны өнөөгийн чиг хандлага, Монгол улсын нөхцөл байдалд үндэслэн оруулсан. Энэхүү босгыг мөн Монгол улсын холбогдох хууль тогтоомжид тусгах боломжтой.
3. Бүртгэлтэй бүх аж ахуйн нэгж өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тайлагнах, тухайн мэдээллийг олон нийтэд ил тод болгох эрх зүйн үндсийг бий болгохын тулд холбогдох хуулийн төсөл боловсруулах болон хэрэгжүүлэхэд шаардлагатай ажиллагааны замын зураг буюу арга хэмжээний саналыг тусгасан.
4. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах хууль тогтоомжийг бий болгох үйл явцад дэмжлэг үзүүлэх боломжтой хууль тогтоогчид болон эрх бүхий талуудыг тодорхойлсон оролцогч талуудын зураглал гаргасан.



5. Монгол улсад эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүрдүүлж буй өнөөгийн үйл явцын дүн шинжилгээ хийсэн.
6. Цуглуулах мэдээллийн төрөл, болон чанартай мэдээлэл хэрхэн цуглуулах үйл явцын саналыг тусгасан. Мэдээлэл цуглуулах үйл явцын нэгдсэн байдлыг хангах зэрэг асуудлыг багтаасан эдгээр зөвлөмжид төр болон хувийн хэвшлийн ойлголтыг нэмэгдүүлэх асуудлууд ч мөн багтсан болно.
7. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг хэрхэн ашиглах болон түүнийг ашигласнаар гарах үр дүнг таниулах мэдээлэл, сурталчилгааны зөвлөмжүүд мөн тайланд багтсан.
8. Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн санг улам бэхжүүлэх болон үүнийг эцсийн өмчлөгчийн бүртгэлтэй уялдуулах талаарх зөвлөмжүүд тусгасан.

## 1.2 ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү тайлан нь 2019 оны Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилгын (ОУИТБС) стандартын дагуу өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллээ ил тод болгох үүрэг хүлээсэн уул уурхайн компаниудад төвлөрөн боловсруулагдсан болно. ОУИТБС-ын стандартын Шаардлага 2.5-ын дагуу ашигт малтмал олборлох тусгай зөвшөөрөл авах хүсэлт гаргаж, тусгай зөвшөөрөл эзэмшиж буй компаниуд нь өөрийн эцсийн өмчлөгчийг ил тод болгосон байхыг шаарддаг<sup>2</sup>. Тайлан нь эцсийн өмчлөгчийн ил тод байдлын талаарх уул уурхайн компаниудын хууль эрх зүйн хүрээнд болон ОУИТБС зэрэг санаачилгын дагуу хүлээсэн үүргийг харгалзан үзсэн. Мөн Санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх олон улсын олон улсын байгууллага (ФАТФ)-ын зөвлөмжүүд гэх мэт Монгол улсын хувьд дагаж мөрдөх шаардлагатай олон улсын стандартыг тайлан бэлтгэх явцдаа судлан үзсэн болно.

Тайлан нь хэдийгээр олборлох үйлдвэрлэлийн салбарт төвлөрөн боловсруулагдсан хэдий ч эцсийн өмчлөгчийн ил тод байдлын нийт эдийн засагт үзүүлэх нөлөөллийг мөн харгалзан үзсэн. Уул уурхайн салбар нь Монгол улсын эдийн засагт томоохон хувь нэмэр оруулдаг ба 2018 оны байдлаар ДНБ-ны 23%-ийг бүрдүүлж байв<sup>3</sup>. Нийт эдийн засгийг хамран судалснаар уул уурхайн салбарын ханган нийлүүлэлтийн сүлжээнд хамаарах компаниудыг ч мөн хамруулан үзэх боломж бүрдэж буй юм.

Түүнчлэн, энэхүү тайланд Монгол улсад одоо ашиглаж буй нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэлд хийсэн үнэлгээг тусгасан. Компани, аж ахуйн нэгжүүдэд хувь эзэмшдэг улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг олж тодорхойлох нь эцсийн өмчлөгчийн ил тод байдлын чухал элемент юм. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг одоогийн хэрэгжиж буй үйл явцтай уялдуулснаар эцсийн өмчлөгчийн мэдээллийн иж бүрдлийг хангаж, давхцал болон хуваагдлаас сэргийлэхээс гадна олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн сайн туршлагыг нэвтрүүлэх суурь хөрс бүрдэх билээ.

## 1.3 АРГА ЗҮЙ

Эцсийн өмчлөгчийн асуудлыг зохицуулсан хууль эрх зүйн орчин, мэдээллийн ханган нийлүүлэлт болон нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэлд үнэлгээ хийсэн энэхүү тайланг бэлтгэхдээ хийхдээ баримт бичгийн судалгаа болон оролцогч талуудтай хийх ярилцлагын аргуудыг хослуулан ашигласан. Судалгаанд Монгол улсын холбогдох хууль тогтоомж, Монгол улстай шууд болон шууд бус хамаарал бүхий олон улсын стандарт, баримт бичгүүд, бусад улсуудын сайн жишээг тус тус судалсан ба дэлгэрэнгүйг Ном зүй хэсэгт харуулав.

Харин ярилцлагын хувьд иргэний нийгэм, хувийн хэвшил, төр болон хууль тогтоох байгууллагын төлөөллийг хамруулж, урьдчилан бэлтгэсэн багц асуулт тавихын зэрэгцээ тухайн хүний туршлага, мэдлэг, ажилладаг салбар зэргээс хамааран уян хатан байдлаар нэмэлт тодруулгууд хийгдсэн. Ярилцлагад оролцсон талууд болон тавьсан асуултын жагсаалтыг Хавсралт 1-ээс үзнэ үү. Ярилцлагаар өгсөн мэдээллийг ерөнхий байдлаар нэгтгэсэн энэхүү тайланд тусгасан бөгөөд аль нэгэн хүний нэрийг тухайлан дурдаж, санал болон байр суурийг нь шууд эш татаагүй болно.

<sup>2</sup> <https://eiti.org/document/eiti-standard-2019>

<sup>3</sup> <https://eiti.org/mongolia>

## 2. Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал

Бүх аж ахуйн нэгж, компаниуд өөрийн эцсийн өмчлөгчийг Улсын бүртгэлийн ерөнхий газарт (УБЕГ) тайлагнан, ил тод болгох үйл явц Монгол улсад анхан шатандаа хэрэгжиж байна. Энэхүү хуулиар заасан үүрэг нь ашгийн төлөөх болон ашгийн бус бүхий л хуулийн этгээдэд хамааралтай. 2018 онд Монгол улс нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль тогтоомждоо нэмэлт өөрчлөлт оруулан энэхүү үүргийг шинээр ноогдуулах болжээ. Хуульд мөн 2019 оны 03 сард орсон нэмэлт өөрчлөлтөөр хуулийн этгээдийн тайлагнах ёстой мэдээллийн жагсаалтад эцсийн өмчлөгчийн мэдээллийг багтаасан байна. Мөн уг нэмэлт өөрчлөлт батлагдахтай зэрэгцэн Татварын ерөнхий хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль батлагдаж 2020 оны 01 сарын 01-нээс өмнө үүсгэн байгуулагдсан аливаа хуулийн этгээд эцсийн өмчлөгчөө тайлагнах тухай хуульчилсан байна. Энэ дагуу 2020 оны 12 дугаар сарын 31 гэхэд аливаа хуулийн этгээд өөрийн эцсийн өмчлөгчийг УБЕГ-т бүртгүүлэх ёстой ажээ. 2020 оны 12 дугаар сарын 23-ны байдлаар нийт 29,948 компани болон бусад хуулийн этгээд өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг УБЕГ-т хүргүүлсэн гэсэн мэдээлэл байна. Бүртгэлийн хуулиар эцсийн өмчлөгчийг Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх хуульд зааснаар тодорхойлно хэмээн заасан. УБЕГ нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд ил тод болгоогүй, мэдээллийг зөвхөн зохицуулах чиг үүрэгтэй болон хууль сахиулах байгууллагуудад л гарган өгч байна.

Улсын бүртгэлийн болон мөнгө угаахтай тэмцэх хууль тогтоомжуудаас гадна эцсийн өмчлөгчийн талаар заасан бусад хэд хэдэн хууль тогтоомж байна. Эдгээрт Татварын ерөнхий хууль болон Банкны тухай хуулиуд багтаж байна. Тухайн хуулиуд нь нь эцсийн өмчлөгчийн талаар өөр өөр тодорхойлолт ашиглах ба жишээ нь ил тод болгон мэдээлэх босго хувь нь ялгаатай байна. Түүнчлэн эцсийн өмчлөгчийн ил тод байдалд нөлөөлөхүйц хоёр хуулийн төсөл мөн яригдаж байна. Эдгээр нь Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл, Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төслүүд юм. Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл нь Монгол улсад ОУИТБС-ын хэрэгжилтийг хангах эрх зүйн үндсийг тавьж, тус санаачилгын стандартыг заавал (одоо сайн дурын) хэрэгжүүлэхээр үүрэг болгох зүйл заалтуудыг багтаасан. ОУИТБС-ыг эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах зорилгоор Монгол улсад хэрэгжүүлснээр гарах үр нөлөөг дараагийн хэсэгт илүү дэлгэрэнгүй харуулсан (Хэсэг 2.3).

Судалгааны багийн ойлгож буйгаар хуулийн төсөл нь 2021 оны 07 сарын УИХ-ын чуулганы завсарлагааны өмнө хэлэлцүүлэхээр төлөвлөгдсөн ч Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл нь УИХ-ын энэ удаагийн чуулганы хэлэлцэх асуудлын жагсаалтад багтаагүй байна. Энэхүү хуулийн төслийг нэлээд хэдэн жил хэлэлцэн, боловсруулсан ч УИХ дээр энэ талаар ямар нэгэн ахиц гараагүй хэвээр байна. Засгийн газрын зүгээс КОВИД цар тахлын эдийн засгийн нөлөөллийг бууруулах чиглэлээр төвлөрөн ажиллаж буй тул энэхүү хуулийн төслийн тэргүүлэх ач холбогдолтой хуулийн жагсаалтад оруулаагүй аж. Түүнчлэн хуулийн төслийг батлуулах чиглэлээр биечлэн манлайлж, ахиц дэвшил гаргах хууль тогтоогч үгүйлэгдэж байна. Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт нь засгийн газрын цахимжуулах хөтөлбөрийн (e-Mongolia гэж заримдаа нэрлэдэг) нэг хэсэг бөгөөд тэргүүлэх чиглэлийн нэг тул дэмжлэг их байна.

Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт батлагдан, хэрэгжиж эхэлбэл төрийн мэдэлд буй их хэмжээний мэдээллийг олон нийтэд нээлттэй болгох боломж нээгдэх юм. Үүний хүрээнд УБЕГ дээр хадгалагдаж буй эцсийн өмчлөгчийн мэдээллийг авах эрх нээгдэнэ. Өөрөөр хэлбэл эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь хуулийн төсөлд зааснаар олон нийтэд ил болгохоор заагдсан мэдээллийн төрөл юм. УИХ нь энэхүү хуулийн төслийг 7 дугаар сард завсарлах энэ удаагийн чуулганаар хэлэлцэх төлөвтэй байгаа бөгөөд энэ оны эцэс гэхэд энэхүү төсөл эцсийн байдлаар хэрэгжиж эхэлнэ хэмээн үзэж байна. Эцсийн өмчлөгчийн мэдээлэл авах эрхийг бий болгох нь Монгол улсын эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр томоохон ахиц болно. Гэсэн ч эсийн өмчлөгчийн мэдээллийг иргэд авахад саад бэрхшээлтэй тулгарах магадлалтай. Дээр дурдсанчлан эцсийн өмчлөгчийн мэдээллийг өнөөг хүртэл цаасан хэлбэрээр хүлээн авч байна. УБЕГ нь мэдээллийг цахимжуулах чиглэлээр ажиллаж буй бөгөөд бүх мэдээлэл цахим болох хүртэл мэдээллийн хүртээмжийг хангах нь цаг шаардсан, мэдээллийн хэрэглээг хязгаарласан (жишээ нь эзэмшлийн сэжигтэй бүтэц, сүлжээг илрүүлэх) байх магадлал өндөртэй байна.

## 2.1 ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ХАРЬЦУУЛАЛТ

### ХҮСНЭГТ 1: Монгол улсад ашиглаж буй “эцсийн өмчлөгчийн” тодорхойлолтуудыг харьцуулсан байдал

Хамаарах хууль	Эцсийн өмчлөгчийн ойлголтод үзүүлэх нөлөөлөл	Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт	Хамрах хүрээ	Босго	Бүртгэлийн байгууллага
<b>Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013</b>	Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтод 2018 онд нэмэлт өөрчлөлт оруулсан	<p><b>3.1.6.</b> “Эцсийн өмчлөгч” гэж:</p> <p><b>3.1.6.а.</b> харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бусдаар төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;</p> <p><b>3.1.6.б.</b> харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;</p> <p><b>3.1.6.в.</b> хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;</p>	Мэдээлэх үүрэгтэй 8 төрлийн этгээдийг тодорхойлсон. Бусад хууль тогтоомжийн хувьд энэхүү хуулийг тодорхойлолтын хувьд эш татдаг боловч хэрэглээний хувьд хамааралгүй байна.	Босго заагаагүй	Хамаарахгүй
<b>Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018</b>	Эцсийн өмчлөгчтэй холбоотой зарим заалтад 2019 онд нэмэлт өөрчлөлт оруулсан	<b>4.1.11</b> “Эцсийн өмчлөгч” гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг	Бүх хуулийн этгээд	Хуульд босго заагаагүй ч эцсийн өмчлөгчийн мэдээлэл бүртгэх маягт дээр 33% хэмээн заасан	УБЕГ
<b>Банкны тухай хууль, 2010</b>	Эцсийн өмчлөгчийн тодорхойлолтод 2018 болон 2021 онуудад нэмэлт өөрчлөлт оруулсан	<b>3.1.17.</b> “эцсийн өмчлөгч” гэж банкны үйл ажиллагааг удирдан чиглүүлдэг, эсхүл өөрийн энэ эрхээ бусдаар төлөөлүүлэн гүйцэтгүүлдэг, эсхүл банкны хувьцааг нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр дамжуулан эзэмшиж байгаа, тухайн хуулийн этгээдийг үүсгэн байгуулсан буюу банкны хувьцаа, үйл ажиллагаанаас үүсэх үр шимийг хүртэх эрх бүхий өмчлөгч хүнийг;	Арилжааны банкууд	Шууд босго заагаагүй ч эцсийн өмчлөгчийн тодорхойлолтод 5 болон түүнээс дээш хувь эзлэх этгээд хамаарна гэж заажээ.	Монгол Банк

Хамаарах хууль	Эцсийн өмчлөгчийн ойлголтод үзүүлэх нөлөөлөл	Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт	Хамрах хүрээ	Босго	Бүртгэлийн байгууллага
Татварын ерөнхий хууль, 2019		<b>6.1.48</b> "эцсийн эзэмшигч" гэж ашигт малтмал, газрын тос, цацраг идэвхт ашигт малтмалын тусгай зөвшөөрөл, газар эзэмших, ашиглах эрх эзэмшигч этгээдийн 30 болон түүнээс дээш хувийн хувьцаа, хувь оролцоо, эсхүл саналын эрхийг өөрөө, эсхүл нэг болон түүнээс дээш үргэлжилсэн хэлхээ холбоо бүхий хуулийн этгээдээр төлөөлүүлэн эзэмшдэг, саналын эрхийг төлөөлүүлэн хэрэгжүүлдэг, эсхүл ногдол ашгийг хүлээн авах эрхтэй этгээдийг.	Уул уурхайн болон газар эзэмших эрх бүхий хуулийн этгээдүүд	30%	Татварын ерөнхий газар
Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013	Эцсийн өмчлөгчтэй холбоотой зүйл дээр 2013 оноос хойш нэмэлт өөрчлөлт ороогүй. Тиймээс ашигласан үг хэллэгийн хувьд ялгаатай.	<b>4.1.26</b> дугаар заалт "бенефициар өмчлөгч" гэж хуульд заасны дагуу номиналь эзэмшигчийн нэр дээр өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг бүртгүүлсэн, тухайн үнэт цааснаас үүсэх үр шимийг хүртэх эрхтэй жинхэнэ өмчлөгчийг;	Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, үнэт цаас эзэмшигчид.	Босго тавиагүй. Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт нь номиналь эзэмшигчээр дамжуулан үнэт цаас эзэмшигч буй буй хуулийн этгээдэд хамаарна.	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв
Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл		<b>4.1.20</b> Татварын ерөнхий хуульд заасан тодорхойлолтыг баримтална	Олборлох үйлдвэрлэлийн салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд	Татварын ерөнхий хуулийн тодорхойлолтыг ашигладаг тул 30%-иар тогтоосон	Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хариуцах "Олборлох үйлдвэрлэлийн салбарын дата бааз" <sup>4</sup>
Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хууль		Тодорхойлолт эсвэл бусад хуулийн заалтыг тусгаагүй. Хуулийн төсөл нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд нээлттэй мэдээлэл хэмээн ангилж, нээлттэй байх шаардлагыг тавьсан	N/A	N/A	N/A

## 2.2 ФАТФ-ЫН ХАРИЛЦАН ҮНЭЛГЭЭНИЙ ҮР ДАГАВАР

2016 онд Монгол улсад мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээ, үүний үр дүнгийн талаар ФАТФ-аас харилцан үнэлгээ хийжээ. Үнэлгээний хүрээнд ФАТФ-ын 24 дүгээр зөвлөмжийн дагуу хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг эрх бүхий байгууллага (жишээ нь хууль сахиулах байгууллага) цаг тухайд нь, шуурхай авах боломжтой эсэхийг үнэлсэн. Монгол улс нь техникийн нийцлийн хувьд "үндсэндээ хангасан" хэмээн үнэлэгдсэн нь эрх бүхий байгууллагуудад эцсийн өмчлөгчийн мэдээллийг авах эрхийг хангах чиглэлээр хангалттай арга хэмжээг авч хэрэгжүүлсэн гэсэн үг юм. Гэвч эдгээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнтэй байдлын хувьд ФАТФ-ын Үр дүн 5-ын хувьд "бага" хэмээн үзжээ. ФАТФ-ын зүгээс гаргасан Үр дүн 11-ийн хүрээнд Монгол улсын авч хэрэгжүүлж буй мөнгө угаах, терроризмтой тэмцэх чиглэлээрх ихэнх арга хэмжээний үр дүнтэй байдал нь бага хэмээн дүгнэжээ. Энэхүү дүгнэлт болон үнэлгээний явцад олж авсан бусад мэдээлэлд үндэслэн Монгол улсыг "нэмэлт хяналт шаардлагатай" улс буюу албан бусаар "саарал жагсаалт" хэмээн нэрлэгддэг улсуудын жагсаалтад оруулсан. Улмаар Монгол улс нь мөнгө угаах, терроризмтой тэмцэх чиглэлээрх сул талуудаа арилгах, үр дүнгээ нэмэгдүүлэх Үйл ажиллагааны төлөвлөгөөг ФАТФ-тай

<sup>4</sup> Хуулийн төсөлд эцсийн өмчлөгчийн мэдээллийг Засгийн газрын хэрэг эрхлэх газрын хариуцах "Олборлох үйлдвэрлэлийн салбарын дата бааз"-д нэгтгэх тухай заажээ. УБЕГ нь энэ мэдээллийг өөрийн баазтай тулгах боловч хоёр тусдаа хадгалагдах ажээ.

хамтран зөвшилцөн гаргасан ба төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлсэн ажиллагааг үнэлсний үндсэн дээр 2020 онд ФАТФ-ын зүгээс Монгол улсыг дээр дурдсан саарал жагсаалтаас хассан байна.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийн чиглэлээрх сул талыг багасгах, үр дүнг нэмэгдүүлэх үйл ажиллагаа дээрх төлөвлөгөөнд тусгагдаагүй ч саарал жагсаалтаас ерөнхий зорилгын хүрээнд Улсын бүртгэлийн ерөнхий хуульд нэмэлт өөрчлөлт оруулан, эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох тухай заалтыг тусгажээ. ФАТФ-ын зүгээс Монгол улсыг саарал жагсаалтаас гаргаснаас хойш эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр Засгийн газраас авч хэрэгжүүлж буй арга хэмжээний эрч буурсан харагдаж байна. Энэ талаар хэд хэдэн оролцогч талын төлөөлөл ярилцлагын үеэр дурдаж байсан (Дэлгэрэнгүйг 4-р хэсэг буюу Оролцогч талуудын оролцоо сэдвээс үзнэ үү). Ийнхүү цаг алдсан, эрч буурсан нь үндсэндээ төр эсвэл хууль тогтоох байгууллагад энэхүү үйл ажиллагааг үргэлжлүүлэн авч явах манлайлагч хомс буйгаас үүджээ.

## 2.3 МОНГОЛ ДАХЬ ОЛБОРЛОХ ҮЙЛДВЭРЛЭЛИЙН ИЛ ТОД БАЙДЛЫН САНААЧИЛГА


Эцсийн өмчлөгчийг тайлагнах талаарх үүргийг өмнө дурдсан хуулиудад тусгайлан зааж өгөхөөс өмнө энэ талаарх ажиллагаа нь ОУИТБС-ын хэрэгжилтээс үүдэн хэрэгжих эхэлжээ. Монгол улс нь ОУИТБС-ийн чиглэлээрх манлайллаа харуулахын тулд 2013 онд анх жилийн тайлангаа гаргаж эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг танилцуулсан нь ОУИТБС-ыг хэрэгжүүлэгч анхны орнуудын нэг болсон юм. Анхны тайлан мэдээллээ ирүүлсэн 250 компаниас 215 нь эцсийн өмчлөгчөө тайлагнан өндөр амжилт гаргасан ч дараа дараагийн жилүүдэд энэ хувь хэмжээ буурсан нь компаниудад энэхүү үүргийг хуулиар ноогдуулаагүй байсантай холбоотой. 2019 оны ОУИТБС-ийн тайланд 2093 компаниас 291 нь эцсийн өмчлөгчийн талаарх ямар нэгэн мэдээлэл ирүүлсэн байна. Монгол улсын хувьд эцсийн өмчлөгчийг тайлагнахад 5%-ийн босго тогтоосон. Гэвч ихэнх тохиолдолд тайлагнагч компаниудын зүгээс эцсийн өмчлөгчийг ном ёсоор нь тодорхойлж, мэдээлэх гэхээсээ илүүтэйгээр хувь эзэмшигчийн мэдээллээ тайлагнасан байна. Монгол дахь ОУИТБС нь өөрийн жил тутмын тайландаа эцсийн өмчлөгчийн мэдээллийг үргэлжлүүлэн цуглуулан, нийтэлсээр ирсэн. Гэвч компаниуд нь заавал биелүүлэх хуулиар тогтоосон үүрэг хүлээгээгүйгээс үүдэн эцсийн өмчлөгчийн үнэн зөв, иж бүрэн мэдээллийг цуглуулах тус санаачилгын боломж хязгаарлагдмал хэвээр байна. Монгол улс дахь ОУИТБС нь хүн хүч болон бусад нөөц, эх үүсвэрийн хувьд хязгаарлагдмал нөхцөлд үйл ажиллагаа явуулж байна. Эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь ОУИТБС-ын стандартын дагуу цуглуулах шаардлагатай мэдээллийн зөвхөн нэг хэсэг бөгөөд татвар төлбөр, орлогын мэдээллийг цуглуулан, нийтэд зориулан хэвлэн нийтлэхэд гол цөм нь оршдог. Монголын ОУИТБС нь өөрийн санхүүжилт, зохион байгуулалтын бүтцийг илүү тогтвортой болгох сорилттой нүүр тулгараад байна.

Монгол улсад бүртгэлтэй бүх компаниуд өөрийн эцсийн өмчлөгчийг УБЕГ-д тайлагнах хуулиар заасан үүрэг болон тухайн мэдээллийг авахтай холбоотой шинээр үүсэх эрх нь уул уурхайн компаниудын эцсийн өмчлөгчийн мэдээллээ тайлагнадаг үйл явцыг тогтмолжуулах боломжийг Монгол дахь ОУИТБС-д Монгол улс дахь бүрдүүлэх юм. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг тус тусдаа цуглуулан, нийтлэхээс илүүтэйгээр УБЕГ-т цаашид хандан гаргуулан авч байх холбогдох талуудад илүү үр дүнтэй байх боломж бүрдэнэ. Монгол дахь ОУИТБС-ын хувьд энэхүү мэдээллийг хэрхэн авах зааварчилгааг гаргах ба үйл ажиллагаагаа, ОУИТБС-ын стандартаар заасан бусад зүйлсэд түлхүү чиглүүлэн ажиллах боломжтой болох юм.


## 2.4 КОМПАНИ, АЖ АХУЙН НЭГЖИЙН БҮРТГЭЛИЙН ҮЙЛ ЯВЦ

Монгол улсад аль ч салбарт, тэр дундаа уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулахаар төлөвлөж буй бүх компани заавал албан ёсоор бүртгэгдсэн аж ахуйн нэгж байх шаардлага тавигддаг. УБЕГ нь аж ахуйн нэгжүүдийг улсын бүртгэлд бүртгэж, бүртгэл мэдээллийн санг хөтлөх чиг үүргийг гүйцэтгэдэг. Доорх Зураг 1 дээр аж ахуйн нэгжийг улсын бүртгэлд бүртгүүлэх үйл явцыг харууллаа.

**ЗУРАГ 1:** Шинээр байгуулагдаж буй хуулийн этгээдийг улсын бүртгэлд бүртгэх ерөнхий үйл явц



**ЗУРАГ 2:** Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн мэдээлэлд өөрчлөлт оруулах ерөнхий үйл явц



Компани, аж ахуйн нэгжийн мэдээллийг хайхын тулд нэр эсвэл бүртгэлийн дугаарыг [Open Data Mongolia](#) сайтад бичиж оруулна.

Энэхүү нээлттэй мэдээллийн санд хуулийн этгээдийн оноосон нэр, хаяг, үйл ажиллагааны чиглэл, хувьцаа эзэмшигч гишүүний мэдээлэл, хууль ёсны өмчлөгчийн нэрс байна.

## OPENDATA МЭДЭЭЛЛИЙН САНГИЙН МЭДЭЭЛЭЛ:

### Үндсэн мэдээлэл

Регистрийн дугаар	Оноосон нэр	Бүртгэсэн огноо	Хэлбэр	Төрөл	Хувьцаа эзэмшигч, гишүүний тоо	Хуулийн этгээдийн хаяг
-------------------	-------------	-----------------	--------	-------	--------------------------------	------------------------

### Итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий албан тушаалтан, эрх барих этгээдийн мэдээлэл

№	Албан тушаал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо
---	--------------	-----------	------------------	-----	-----------------

### Хувьцаа эзэмшигч, гишүүний мэдээлэл

№	Ангилал	Улсын нэр	Эцэг/эх/-ийн нэр	Нэр	Бүртгэсэн огноо
---	---------	-----------	------------------	-----	-----------------

### Үйл ажиллагааны чиглэлийн мэдээлэл

№	Үйл ажиллагааны код	Үйл ажиллагааны чиглэл	Бүртгэсэн огноо
---	---------------------	------------------------	-----------------

## 2.5 НИЙТИЙН АЛБАН ХААГЧДЫН ХӨРӨНГӨ, ОРЛОГЫН МЭДҮҮЛЭГ

Авлигатай тэмцэх газар (АТГ) нь нийтийн албан хаагчдын хөрөнгө, орлогын мэдүүлгийг хариуцан, хүлээн авах болон шалгах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Ойролцоогоор 40,000 орчим нийтийн албан хаагч жил тутам өөрийн хөрөнгө орлогын мэдүүлгийг гарган, компани аж ахуйн нэгжид эзэмшиж буй хувь, эд хөрөнгө болон бусад хөрөнгөө (жишээ нь мал гэх мэт) мэдүүлэх үүргийг хуулийн дагуу хүлээдэг. Тайланд жилийн хугацаанд хөрөнгө орлогын мэдүүлэгт ямар нэгэн өөрчлөлт гаргах тохиолдолд энэ талаар 30 хоногт багтаан мэдүүлэх үүрэгтэй. Хөрөнгө, орлогын мэдүүлэг нь хязгаарлагдмал байдлаар олон нийтэд нээлттэй бөгөөд мэдүүлгийн маягттай харьцуулбал хялбаршуулсан байдлаар мэдээлэл нь цахим хуудаст тавигддаг. Дэлгэрэнгүй лавлагааг авахын тулд АТГ-т бичгээр хүсэлт гаргах ёстой. Хөрөнгө орлогын мэдүүлгээ албан ёсоор мэдүүлэх үйл явц өндөр түвшинд явагдаж буй ч тухайн мэдүүлгийн бүрдэл, үнэн зөв байдлыг шалган баталгаажуулах үйл явц хэр баталгаатай вэ гэдэг нь эргэлзээтэй. Транспаренси Интернейшнлийн зүгээс хөрөнгө орлогын мэдүүлгийн хэрэгжилтийг доогуур хэмээн үнэлж, төрийн албан хаагчид халдашгүй байдлын хамгаалалт өндөртэй, зөрчсөн тохиолдолд ноогдуулах торгууль, шийтгэлийн хэмжээ үр дүн багатай хэмээн тэмдэглэжээ.

Нийтийн албан хаагчийн хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл нь эцсийн өмчлөгчийн асуудлыг чухал бүрэлдэхүүн хэсэг юм. Мөн Монгол улсад бүртгэлтэй компаниудын эцсийн өмчлөгч болох улс төрд нөлөө бүхий этгээдүүдийг олж тогтооход чухал үүрэг гүйцэтгэх юм. УБЕГ дээр хэрэгжүүлж буй эцсийн өмчлөгчийг ил тод тайлагнах систем нь эцсийн өмчлөгч нь улс төрд нөлөө бүхий этгээд эсэхийг тайлагнах шаардлагыг тусгаагүй ч Монгол улсын хувьд улс төрд нөлөө бүхий этгээдүүд нь өөрийн аж ахуйн нэгж, компани дахь эзэмшлийн хувь хэмжээгээ мэдүүлэх системтэй тул энэ нь байж болох зүйл юм. Гэвч хөрөнгө орлогын бүртгэл болон эцсийн өмчлөгчийн бүртгэл нь харилцан уялдаатай ажиллаж, хянан баталгаажуулалтад ашиглагдах ёстой. Нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэгт

багтсан аж ахуйн нэгж, компанид эзэмшиж буй хувь хэмжээг эцсийн өмчлөгчийн бүртгэлийн мэдээлэлтэй тулган шалгах хэрэгтэй. УБЕГ болон АТГ нь мэдээлэл харилцан солилцдог хэмээн судалгааны баг ойлгож байна. УБЕГ нь олон нийтэд хандан гаргаж буй мэдэгдэлдээ эцсийн өмчлөгчийг тайлагнах үүргийн гүйцэтгэлийг хангуулах, үйл ажиллагаа явуулаагүй аж ахуйн нэгжүүдийг тогтоох, бүртгэлээс хасах зэрэг чиглэлд анхааран ажиллахаа мэдэгдсэн. Сүүлийн мэдээллээс харахад УБЕГ-д бүртгэлтэй аж ахуйн нэгжүүдийн ихэнх хувь нь үйл ажиллагаа явуулаагүй байна.

Өнөөдөр Монгол улсад эцсийн өмчлөгчийн мэдээлэл олон нийтэд хүртээмжгүй байгаа нь иргэд, иргэний нийгмийн байгууллагууд болон бусад хэрэглэгчид тухайн хоёр бүртгэлийн мэдээллийг харьцуулан, мэдээллийн үнэн бодит байдлыг хянан баталгаажуулагчийн үүрэг гүйцэтгэх боломжийг нь хязгаарлаж байгаа юм. Иргэд, иргэний нийгмийн болон бизнесийн байгууллагууд мэдээллийг тал талаас нь “олон нүдээр” харж, зөрүүг олж тогтоон, компаниудын бодитоор хэн эзэмшиж буйг тодорхойлох, бодит болон боломжит ашиг сонирхлын зөрчлөөс зайлсхийх боломжид эцсийн өмчлөгчийн бүртгэл, хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэлийн гол ач холбогдол оршиж байгаа юм. Жишээ нь бизнес эрхлэгчид нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл, улс төрд нөлөө бүхий этгээдийн мэдээллийг ашиглан өөрийн хийж буй худалдан авалтын үйл ажиллагааг ямар нэгэн хөндлөнгийн нөлөөлөл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгах боломжтой.



## 3. Эцсийн өмчлөгчийн чиглэлээрх олон улсын стандарт ууд

### 3.1 ОУИТБС-ЫН ШААРДЛАГУУД

2003 онд анхлан хэрэгжиж эхэлсэн цагаас хойш ОУИТБС нь олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын жишиг болж, тус санаачилгын Стандарт нь энэхүү ил тод байдлын талаарх тодорхой чиглэл, хүрээллийг тогтоогоод байна. 2013 онд гарсан ОУИТБС-ын стандарт нь эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр зөвлөмжийг багтаасан ба үүнийг хоёр жилийн хугацаанд туршин хэрэгжүүлсний үндсэн дээр 2016 гарсан стандартаар эцсийн өмчлөгчийг ил тод мэдээлэх шаардлагыг тавих болжээ. Өнөөгийн байдлаар ОУИТБС-ын 2019 оны Стандартын Шаардлага 2.5 нь тус санаачилгыг хэрэгжүүлэгч бүхий л улс орнуудыг уул уурхайн тусгай зөвшөөрөл эзэмшиж, үйл ажиллагаа явуулж, зөвшөөрөл авахаар хүсэлт гаргаж буй бүх компани, аж ахуйн нэгжид эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулан, нийтэлж байх шаардлагыг тавьж байна.

ОУИТБС-ын Стандарт нь хэрэгжүүлэгч улс орнуудад зориулан эцсийн өмчлөгчийн тодорхойлолтыг тусгайлан гаргаагүй ч хамаарах тодорхойлолтод баримтлах шаардлагатай шалгуурыг тухайн стандарт болон дагалдах баримт бичгүүдэд заан өгсөн. Үүнд:

- Компанийн хувьд эцсийн өмчлөгч нь тухайн аж ахуйн нэгжийг шууд эсвэл шууд бусаар эзэмшиж эсвэл хяналтдаа байлгаж буй хувь хүнийг хэлнэ.
- Энэхүү шаардлага нь байгалийн хий, газрын тос болон ашигт малтмал олборлох эрх авахаар өргөдөл гаргаж буй болон олборлож буй, гэрээ хэлцэл байгуулж буй аж ахуйн нэгжид хамааралтай бөгөөд тухайн аж ахуйн нэгж нь өөрийн эцсийн өмчлөгчийн нэр, өмчлөлийн түвшин, хяналт болон эзэмшлийг хэрхэн хэрэгжүүлж буй хэлбэрийг дэлгэрэнгүй мэдээлнэ.
- Тодорхойлолт нь мөн улс төрд нөлөө бүхий этгээдүүдийн хувьд тайлагнах үүргийг тусгасан байх ёстой.
- Нээлттэй компаниуд, үүнд мөн тэдний эзэмшилд байдаг салбар компаниуд нь өөрийн бүртгэлтэй хөрөнгийн биржийн нэрийг ил тод нийтэлнэ.
- Эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь тухайн өмчлөгчийн нэр, харьяалал, оршин сууж буй улс болон улс төрд нөлөө бүхий этгээд мөн эсэхийг заасан байна. Мөн иргэний бүртгэлийн баримт бичгийн дугаар, төрсөн огноо, албаны эсвэл хувийн оршин суугаа хаяг болон холбоо барих мэдээлэл зэргийг багтаасан байна.
- ОУИТБС-ын зүгээс мөн эцсийн өмчлөгчийг тайлагнах эзэмшлийн босго хувийг тогтоохыг зөвлөдөг ба 5-25%-ийг босго дүнг зөвлөмж болгодог.

ОУИТБС нь эцсийн өмчлөгчийн хамрах хүрээ, тодорхойлолтыг батлан гаргахын тулд тухайн хэрэгжүүлэгч улсын хувьд Олон талын оролцоот бүлэг (ОТОБ)-ийг байгуулж дотоодын нөхцөл байдал, тайлагнах шаардлагууд, олборлох үйлдвэрлэлийн салбарын онцлогийг харгалзан үзсэн байх шаардлагыг тавьдаг.

ОУИТБС-ын стандартын дагуу тус санаачилгыг хэрэгжүүлэгч улс орнууд нь жил тутам өөрийн тайланг гаргадаг бөгөөд энэхүү тайланд эцсийн өмчлөгчийн мэдээлэл багтсан байхыг шаарддаг ажээ. Гэхдээ сүүлийн үед энэхүү тайланг илүү системтэй байдлаар ил тод мэдээлэх боломжийг хайх болжээ. Өөрөөр хэлбэл, ОУИТБС-ын шаардлагад хамаарах мэдээллийг бусад эрх бүхий байгууллагууд бодит цагийн горимоор ил тод болгож буй тохиолдолд заавал жил тутмын тайланг хүлээх шаардлагагүй юм. Гэхдээ л эцсийн өмчлөгчийг мэдээллийг жил тутам цуглуулах, нийтлэх нь өнөөгийн ОУИТБС-ын хүрээнд түгээмэл байна.

### 3.2 САНХҮҮГИЙН ГЭМТ ХЭРЭГТЭЙ ТЭМЦЭХ БОЛОН УЛСЫН БАЙГУУЛЛАГА(ФАТФ)-ЫН ШААРДЛАГУУД

1989 онд G7 буюу их долоон гүрнүүд хамтран мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилгоор ФАТФ-ыг анх байгуулсан ба энэ зорилго нь өнөөг хүртэл ФАТФ-ын гол үйл ажиллагааг тодорхойлж байна. ФАТФ нь стандарт тогтоож, бодлого боловсруулж, зөвлөгөө өгдөг хэдий ч гаргасан стандартыг нь улс орнууд ОУИТБС шиг шууд дагаж мөрдөх үүрэг хүлээдэггүй.

Тус байгууллагын гол цөм нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх стандартыг тогтоосон 40 зөвлөмж байдаг. Одоо хүчин төгөлдөр буй Зөвлөмж анх 2012 онд баталж, түүнээс хойш холбогдох нэмэлт өөрчлөлт оруулсаар ирсэн. Хамгийн сүүлд 2018 оны 2 дугаар сард нэмэлт өөрчлөлт орсон бөгөөд эцсийн өмчлөгчтэй холбоотой зөвлөмжид үндсэн өөрчлөлт гараагүй байна.

ФАТФ-ын зөвлөмжүүд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх олон улсын жишиг болоод байна. ФАТФ-аас гаргасан бодлогын зөвлөмжүүдийг олон улс орнууд, тэр дундаа гишүүнчлэлгүй улс орнууд даган хэрэгжүүлж, бодлогынхоо үндэс суурь болгож ирлээ.

ФАТФ болон түүний бүс нутгийн салбар байгууллагууд нь өөрийн гишүүнчлэлд хамаарах улс орнууд дээр дурдсан Зөвлөмжүүдийг хэрхэн биелүүлж буй байдалд үнэлгээ хийн “Зөвлөмжийг хэрэгжүүлдэггүй”, “Зөвлөмжийг хэсэгчилсэн байдлаар хэрэгжүүлдэг”, “Зөвлөмжийг үндсэндээ хэрэгжүүлсэн”, “Зөвлөмжийг нэг бүрчлэн хэрэгжүүлсэн” гэсэн 4 үнэлгээ өгдөг. Мөн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнтэй байдалд үнэлгээ хийдэг.

Зөвлөмж 24 болон 25 (24, 25) нь хуулийн этгээд болон траст гэх мэт бусад хэлбэр бүхий бүтэц зохион байгуулалтын эцсийн өмчлөгчийн асуудлыг хамардаг. Харин тухайн зөвлөмжийн дагуу улс орнуудын авч хэрэгжүүлж буй арга хэмжээний үр дүнтэй байдлыг Үр дүн 5-ын хүрээнд үнэлдэг.

Улс орнууд нь Зөвлөмж 24 болон 25-ын техник хэрэгжилтийг хангасан хэдий ч Үр дүн 5-ын хувьд үнэлгээ доогуур авч болох тул холбогдох арга хэмжээний уялдаа холбоо, үр дүнг хангах нь чухал.

ФАТФ-ын шаардлагын дагуу улс орнууд нь дараах арга хэмжээг авах ёстой:

- Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон хяналтын тухай мэдээлэл нь үнэ зөв, эцсийн байдлаар хадгалагдах ба эрх бүхий байгууллагууд цаг тухайд нь шуурхай авах боломжоор хангагдсан байх;
- Дамжуулах хувьцаа (bearer share) гаргах эсвэл дамжуулах хувьцааны итгэмжлэл олгох хуулийн этгээд болон нэрлэсэн хувьцаа эзэмшигчтэй эсвэл нэрлэсэн захиралтай компаниудын хувьд мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх зорилгоор ашиглагдахгүй байхаас сэргийлэх үр дүнтэй арга хэмжээг авч хэрэгжүүлэх;
- Санхүүгийн байгууллага болон санхүүгийн бус мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч нар нь эцсийн өмчлөгч болон хяналтын тухай мэдээллийг авах боломжоор хангагдсан байх;
- Компанийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг тухайн компани өөрөө болон эрх бүхий байгууллагын зүгээс цаг тухайд нь тодорхойлон гаргаж байх.

Тухайн зөвлөмжүүдийг биелүүлэхийн тулд улс орнууд нь доорх механизмуудыг дангаар нь болон хослуулан ашиглах шаардлагатай:

- Бүртгэлийн байгууллага нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг авч, хадгалж байхыг шаардах (Бүртгэлийн арга хандлага);
- Хуулийн этгээд нь эцсийн өмчлөгчийн хамгийн сүүлийн үеийн мэдээллээ бэлэн хадгалж байхыг шаардах (Компанийн арга хандлага);
- Бэлэн буй боломжит мэдээллийг ашиглах (Боломжит мэдээллийг арга хандлага). Практик дээр энэ нь санхүүгийн байгууллагууд эсвэл бусад зохицуулалт бүхий байгууллагуудын харилцагчаа таньж мэдэх үйл ажиллагааны үед цуглуулсан мэдээлэл болон эрх бүхий бусад байгууллагын мэдээлэл эсвэл хөрөнгийн биржийн мэдээллийг ашиглахыг хэлнэ.

ФАТФ-ын зүгээс тайлагнах босго хувийг тусгайлан заагаагүй ч 25% эсвэл үүнээс доогуур хувиар тогтоох нь шаардлагыг даган мөрдөж буйг харуулна хэмээн үздэг.

#### КЕЙС СУДАЛГАА: ГАНА УЛС

ОУИТБС нь Африкийн улс орнуудад өргөн хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд Гана улс нь ОУИТБС-ыг идэвхтэй хэрэгжүүлэгч улс юм. Гана улс Компанийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт болон 2018 оны Компанийн тухай хуулийн төслөөр эцсийн өмчлөгчийн асуудлыг эдийн засгийн хүрээнд хуульчилсан Африк тивийн анхны улс юм. Энэхүү арга хэмжээг авч хэрэгжүүлэхэд ФАТФ-ын зөвлөмж гол түлхэц болжээ.

Хуульд заасан чиг үүргийг Улсын Ерөнхий бүртгэгчийн алба хариуцдаг. Хэдий албан ёсоор заагаагүй ч тус албаны дарга нь энэхүү үйл ажиллагааг манлайлж, эрх зүйн шинэчлэлийн хүрээнд энэхүү үүргээ гүйцэтгэж байна.

2020 онд Гана улс нь олон улсын болон дотоодын мэргэжилтнүүдээс техникийн туслалцаа авсан ба уг тайланг бэлтгэсэн судалгааны багийн 2 гишүүн техникийн туслалцааны багт ажилласан.

Гана улс нь эцсийн өмчлөгчийн асуудлыг зохицуулах, ФАТФ-ын зөвлөмжүүдийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд эцсийн өмчлөгчийн зохицуулалтыг бий болгосон. Үүний хүрээнд эцсийн өмчлөгчөө тайлагнах босгыг 20% болгон тогтоожээ. Улмаар Гана улс нь энэ шинэчлэлийг гүнзгийрүүлж тодорхой ангиллын аж ахуйн нэгжүүдэд ялгаатай босго тогтоосон байна. “Өндөр эрсдэлтэй” хэмээн тооцогдох салбарт үйл ажиллагаа явуулж буй хуулийн этгээд (олборлох болон санхүүгийн салбар) нь 10%-ийн босготой ба гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээдэд ч мөн энэхүү босго хамаарах ажээ. Мөн дотоодын улс төрд нөлөө бүхий этгээдийн хувьд ямар нэгэн босго хувь тогтоогоогүй ба аж ахуйн нэгжид буй эзэмшил эсвэл хяналтын хувь хэмжээнээс үл хамааран тайлагнах үүрэгтэй.

Эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр Гана улсын гаргасан амжилт нь доор дурдсан цогц арга хэмжээний үр дүнд бий болсон байна. Үүнд:

- Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын чиглэлээр ажиллах үндсэн багийн бүрдүүлсэн ба тухайн багийг удирдан чиглүүлэгч нь бүртгэлийн байгууллагын дарга буюу энэ санаачлагыг гол манлайлагч байв.
- Баг нь дараах 3 санаачлагыг зэрэг хэрэгжүүлсэн. Үүнд:
  - **Техникийн үйл ажиллагаа** – Эцсийн өмчлөгчийн талаар одоогийн мөрдөж буй хууль тогтоомжийн заалтыг судалж орхигдуулсан гол элемент, хамрах хүрээг тодорхойлон гаргасан. Үүний дараагаар тэрхүү орхигдуулсан зүйлсийг тусгасан нэмэлт өөрчлөлтийг боловсруулан, батлуулах ажиллагаа хийгдэв.
  - **Сургалт** – Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын зарчим болон дэлгэрэнгүй мэдээллийг бүхий л оролцогч талуудад хүргэсэн ба үүнд хувийн хэвшлийн байгууллагууд ч хамрагджээ. Явуулах хэлбэрийн хувьд сургалт семинар, нээлттэй өдөрлөг, цуврал онлайн сургалт, видео цуврал зэргийг хослуулан зохион байгуулсан байна.
  - **Систем хөгжүүлэлт** – Хууль тогтоомж, дүрэм журамд заасан мэдээллийг онлайн хэлбэрт хөрвүүлэх боломжтойгоор цуглуулах ажлыг зохион байгуулсан. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг түр хадгалах бүртгэл үүсгэж, цаашид онлайн хэлбэрээр тайлангаа ирүүлэх механизм бүрдүүлэхээр ажиллаж байна.
- Эдгээр бүх үйл ажиллагааг хэрэгжүүлэхдээ талуудын уялдаа, харилцаа холбоог өндөр түвшинд хангасан ба бүртгэлийн байгууллагын удирдлага нь энэхүү зохицуулалтын хэрэгжилтийн талаар хэвлэл мэдээллийн хэрэгслүүдээр тогтмол мэдээлэл өгч байжээ.

## **Дизайн болон хэрэгжилт**

Тухайн улс орнуудын нөхцөл байдал, зорилтуудаас хамааран олон улсын хувьд авч хэрэгжүүлсэн гурван төрлийн сайн туршлага байдаг.

Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх эхний арга зам нь ОУИТБС-ын стандартыг амжилттай хэрэгжүүлж, тухайн салбарт үйл ажиллагаа явуулж буй бүх компаниудад зориулсан дэлгэрэнгүй мэдээллийг хэвлэн нийтэлж гаргахтай холбоотой юм. Энэ тохиолдолд зөвхөн олборлох үйлдвэрлэлийн салбараар хэрэгжилт хязгаарлагдах ч ОУИТБС-ын хүрээнд бий болгох эцсийн өмчлөгчийн ил тод байдал нь энэ чиглэлээр хийгдэх инновацийн тэргүүлэх жишиг болж өгнө. Энэ чиглэлээр олон улсын энэхүү сайн туршлагыг хэрэгжүүлсэн улсын тоонд Армени улс орно.

Олон улсын сайн туршлагыг хэрэгжүүлэх дараагийн арга замыг ФАТФ-ын зөвлөмжүүдийг хэрэгжүүлэх чиглэлээр дамжуулан бий болгох боломжтой. Энэ төрлийн туршлагыг хэрэгжүүлсэн улс орнуудын хувьд эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтэд ил тод болгоогүй ч 25% хүртэл босготойгоор, баталгаажсан мэдээлэл бүхий төвлөрсөн бүртгэлийг үүсгээд байна.

Олон улсын сайн туршлагыг хангах дараагийн арга зам нь нийт эдийн засгийг хамарсан, эцсийн өмчлөгчийн, олон нийтэд нээлттэй бүртгэлийг бий болгон хэрэгжүүлэх явдал байна. Энэхүү хандлагын хүрээнд ОУИТБС-ын Стандарт болон ФАТФ-ын зөвлөмжүүдээс хамгийн сайн элементийг нь авч хэрэглэх нь хамгийн сайн бөгөөд бүх нөхцөлд тохирсон арга зам хэмээн тооцогддог. Энэхүү арга замыг сонгон хэрэгжүүлсэн улсуудын тоонд ЕХ-ны гишүүн улсууд (ЕХ-ны Мөнгө угаахтай тэмцэх 4 дүгээр зааварчилгааны хүрээнд), ИБУИНВУ болон Украин багтана.

Дээрх 3 төрлийн сайн туршлагаас харвал эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр хэрэгжүүлж болох нийтлэг хүчин зүйлс байгаа бөгөөд эдгээрийг товчлон хүргэвэл:

- **Хувь хүн.** Олон улсын сайн туршлагын бүхий л жишээнээс харвал эцсийн өмчлөгч нь хувь хүн байх үзэл баримтлал дээр суурилдаг;
- **Эзэмшил болон хяналт.** Олон улсын сайн туршлагаас харвал аж ахуйн нэгжийн эцсийн эзэмшигч нь тухайн аж ахуйн нэгжийг хангалттай хувьд хэмжээнд эзэмшдэг эсвэл хангалттай хэмжээнд хяналтдаа байлгадаг байна;
- **Шууд болон шууд бус.** Олон улсын сайн туршлага нь аж ахуйн нэгжийг шууд эзэмшиж, хяналтаа байлгаж буй этгээдийг хамруулахын зэрэгцээ тухайн компанийг шууд бусаар эзэмшиж буй этгээдүүдийг багтаадаг.
- **Эзэмшлийн босго хувь.** Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хэрэгжүүлж буй улс орнуудын хувьд 25%-ийн босго тавих нь түгээмэл байна. Энэ нь ОУИТБС-ын хүрээнд тогтоосон босго бөгөөд ФАТФ-ын зөвлөмжид бүрэн нийцэж буй юм. Гэхдээ зарим улсын хувьд 25%-иас бага босго тогтоосон ба эцсийн өмчлөгчийн талаар цуглуулж буй мэдээллийг хэмжээг нэмэгдүүлэх, мөнгө угаах болон санхүүгийн гэмт хэрэг үйлдэх эрсдэлийг бууруулах зорилгоор энэхүү хувь хэмжээг аль болох доошлуулах чиглэлээр олон улсын зүгээс улс орнуудад чиглэл өгч байна. Тиймээс олон улсын сайн туршлагаар хамгийн түгээмэл тогтоож буй 25%-ийг багасгах хандлага ажиглаж байна.

## **Шууд бус хяналт**

Шууд бус хяналт гэдэг нь эцсийн өмчлөгчийн хувьд тодорхойлолт гаргахад хамгийн хүндрэлтэй элемент бөгөөд аливаа хувь хүн хуулийн этгээдийг хяналтдаа байлгах олон төрлийн арга зам байдаг. Эдгээрийн зарим нь албан бус хэлбэрээр илэрдэг тул баримт бичиг байхгүй, шууд олж тогтооход хүндрэлтэй байдаг. Олон улсын сайн туршлага нь хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн шууд болон шууд бус хяналтыг харгалзан үзэх хэрэгцээг багтаадаг.

Өөрийн эцсийн өмчлөлийг нуун далдлахын тулд тухайн хувь хүмүүс нь олон тооны арга ашиглаж болох юм. Тиймээс “шууд бус хяналт” хэмээх тодорхойлолт нь олон талын асуудлыг тусгасан, уян хатан хэлбэртэй байж гэмээнэ эцсийн өмчлөлөө нуух аливаа оролдлогоос сэргийлэх боломжийг бүрдүүлэх юм. Олон улсын хэмжээнд хүлээн зөвшөөрөгдсөн шууд бус хяналтыг заасан тодорхойлолт байдаггүй ч үүнд холбоотой заавар байдаг. Жишээ нь ФАТФ нь хэд хэдэн жишээг гарган ирсэн ба эдгээрийг дурдвал

- Олон шатлалд бүтцээр дамжуулан удирдах;
- Хувь нийлүүлэгчийн гэрээ зэрэг гэрээ хэлэлцээрийн хүрээнд удирдах;
- Ямар нэгэн байдлаар тодорхойлоогүй “давамгай нөлөөлөл”-тэй байх;
- Дээд удирдлагыг томилох болон чөлөөлөх боломж;
- Хувийн хэлхээ холбоо;
- Хуулийн этгээдийг санхүүжүүлэх замаар удирдах;
- Дээд удирдлагын үүрэг гүйцэтгэх.

“Шууд бус хяналтыг” тодорхойлоход ашиглагддаг “давамгай нөлөөлөл” “хувийн хэлхээ холбоо” зэрэг нэр томъёо нь эргээд хэрэглээний хувьд ихээхэн сорилт учруулдаг. Яагаад гэвэл энэ төрлийн хяналтыг албан бусаар тавьж болох тул ямар нэгэн баримт бичиг байхгүй. Хувийн хэлхээ холбооны зарим хэлбэр болох гэр бүлийн холбоо тодорхой харагддаг бол зарим төрлийн хэлхээ холбоог олж тогтооход хүндрэлтэй. Жишээ нь хамт сургууль төгссөн, цэрэгт байсан болон хамтран бизнес эрхэлж байсан хэлхээ холбоог тогтооход хүндрэлтэй.

## **Хэрэглээний кейс**

Олон улсын туршлагаас харвал эцсийн өмчлөгчийн ил тод байдлын үр дүнтэй тогтолцооны дизайн болон эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглахын хооронд шууд хамаарал байдаг. Эцсийн өмчлөгчийн мэдээллийн хэрэглэгчид нь төрийн байгууллагууд, хууль сахиулах байгууллагууд, санхүүгийн байгууллагууд болон бусад зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг бүтцүүд, гадаад улсын эрх бүхий байгууллагууд болон хувийн хэвшил юм. Эдгээр хэрэглэгчдэд мөнгө угаах болон бусад эрүүгийн хэргийг мөрдөн шалгаж буй хууль сахиулах байгууллагуудын мөрдөгч нараас эхлээд өөрийн харилцагчийг таньж мэдэх ажиллагаа явуулж буй хувийн хэвшлийн жижиг, дунд бизнесүүд багтана.

Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын сайн туршлагыг хэр үр дүнтэй хэрэгжүүлэх нь тухайн мэдээлэл нь хэр цогц байдлаар цуглуулагдсан болон хандалт нь хэр нээлттэй байгаагаас шууд хамаарна. Тиймээс ихэнх хэрэглэгчдийн хувьд эцсийн өмчлөгчийн мэдээллийг төрийн зүгээс ил тод болгох нь чухал юм. Гэхдээ хувийн хэвшил үүнийг ашиглан, өгөөжийг нь хүртэхийн тулд тухайн бүртгэлд олон нийт нэвтэрч, өөрийн ханган нийлүүлэгч, түншлэгчид, үйлчлүүлэгчид болон өрсөлдөгчийн эцсийн өмчлөгчийг тодорхойлох боломжтой хэмжээнд байх ёстой.

Тиймээс эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хамгийн өргөн хүрээнд ашиглах олон улсын сайн туршлага нь чөлөөтэй авах боломжтой, нээлттэй бүртгэл байснаар бүрддэг.

## ***Харилцаа холбоо***

Эцсийн өмчлөгчийг ил тод болгох бүтэц, дизайн нь үр дүнтэй байхын тулд бүхий л явцын туршид олон тооны оролцогч талууд хооронд харилцаа холбоог хангах шаардлагатай. Энэхүү харилцаа холбоог хууль тогтоомж батлах, тогтолцоо бүрдүүлэх шатнаас эхлээд мэдлэг бий болгох болон техник хэрэгжилтийн үе шат хүртэл тогтмол бүрдүүлэх шаардлагатай. Өөрөөр хэлбэл олон улсын сайн туршлагаас харвал бүхий үе шатанд мэдээлэл харилцаа холбоог оролцогч талуудтай хангах ба тухайн талууд гэдэгт төрийн байгууллагууд (гаргуулан авсны дараа эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглах), бодлого боловсруулагчид, хууль тогтоогчид, эрх бүхий бусад байгууллагууд, санхүүгийн байгууллагууд болон бусад зохицуулалтын хүрээнд үйл ажиллагаа явуулдаг байгууллагууд болон хувийн хэвшил (мэдээлэл тайлагнагч болон ашиглагчид) болон иргэний нийгэм багтана.

Энэхүү мэдээлэл харилцаа холбоо нь эцсийн өмчлөгчийн ил тод байдлын үр дүнтэй бүтэц, дизайн, хэрэгжилтийг дэмжиж өгөхөөс гадна цуглуулсан мэдээллийн чанарыг сайжруулах, тухайн мэдээллийг авч буй бүхий л талууд үүнийг ашиглан өгөөжийг нь хүртэхэд чухал ач холбогдолтой байдаг.

## 4. Оролцогч талуудын зураглал, оролцоо

Засгийн газар, иргэний нийгэм болон бизнесийн оролцогч талууд нь эцсийн өмчлөгчийн үр дүнтэй системийг хэрэгжүүлэх, эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглан авлига болон санхүүгийн гэмт хэрэгтэй тэмцэх, бусад эрсдэлийг (жишээ нь ашиг сонирхлын зөрчил) удирдах зэрэгт чухал үүргийг гүйцэтгэдэг. Төр нь хууль тогтоомж гарган хэрэгжүүлэхийн зэрэгцээ эцсийн өмчлөгчийн бүртгэлийн үйл ажиллагааг эрхэлнэ. Төрийн байгууллагууд нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг авлигаас сэргийлэх, мөрдөн шалгах үйл ажиллагаанд ашигладаг. Эцсийн өмчлөгчийн мэдээлэл нийтэд ил нээлттэй буй тохиолдолд иргэний нийгэм, бизнесийн байгууллага нь мөн тухайн мэдээллийн гол хэрэглэгч болно. Иргэний нийгэм нь эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглан болзошгүй ашиг сонирхлын зөрчил, авлига болон бусад сэжигтэй үйл ажиллагааг олж тогтооно. Тэд мөн тухайн мэдээллийг ашиглан төр болон бизнесийн салбарыг хариуцлагатай байлгадаг. Эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд ил тод болгосон улс орнуудын туршлагаас үзвэл бизнес эрхлэгчид, ялангуяа жижиг, дунд бизнес эрхлэгчид өөрийн үйлчлүүлэгчид, бизнесийн түншүүд болон өрсөлдөгчид дээрээ магадлан шинжилгээ (due diligence) хийх зорилгоор ашигладаг байна. Тэд мөн мэдээлэл ашиглан өөрийн бизнесийн эрсдэлийг тодорхойлж буйн нэг жишээ нь өөрсдийнхөө талаарх худал мэдээлэл өгч буй ханган нийлүүлэгч, ёс зүйгүй хууль бус худалдан авалт зэргийг олж тогтоох явдал юм.

Энэхүү төслийн судалгааны хүрээнд төр, иргэний нийгэм болон бизнесийн төлөөлөлтэй хийсэн ярилцлагыг багтаасан. Ярилцлагад хамрагдсан байгууллагуудын жагсаалтыг Хавсралт 1 дээр оруулав.

Ярилцлагаар дараах гол санаа илэрхийлэв:

- Бүх компани, аж ахуйн нэгж УБЕГ-т өөрийн эцсийн өмчлөгчийг бүртгүүлэхийг хуулиар шаарддаг болсон талаар өргөн хүрээнд мэддэг болсон. Ярилцлагад хамрагдсан хүмүүсийн дийлэнх нь энэхүү арга хэмжээг эергээр хүлээн авсан. Мөн ихэнх оролцогчид эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд ил тод болгохыг дэмжиж байсан ч төрийн байгууллагуудын зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил болгох талаар эргэлзэж байв. Тэдний хувьд төрийн байгууллагууд хоорондоо мэдээллээ солилцож, өөрийн чиг үүргээ илүү үр дүнтэй гүйцэтгэх нь зөв хэмээн үзэж байв.
- Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр Засгийн газрын хүчин чармайлт суларч байна. Энэ нь КОВИД-19 цар тахлын үр дагаварыг бууруулах чиглэлээр Засгийн газар анхаарал түлхүү хандуулж буйтай холбоотой бөгөөд ФАТФ-ын шаардлагуудыг хангах, авлигатай тэмцэх зэрэгт тэргүүлэх ач холбогдол өгөхгүй байна.
- Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг шийдвэр гаргах түвшинд тогтмол анхаарах нөхцөл бүрдүүлэх чадвар бүхий удирдан манлайлагч Монгол Улсад дутагдаж байна. Манлайлагч нь цаашид хийгдэх шинэтгэлийг тэргүүлж, эцсийн өмчлөгчийн ил тод байдлын ач холбогдлын талаар мэдлэг бий болгож, авлигатай тэмцэхэд үүрэг гүйцэтгэх шаардлагатай байна.
- Уул уурхайн салбарт ил тод байдал дутмаг байна. Тусгай зөвшөөрлийг хэн эзэмшиж буй нь асуудал болж байгаа бөгөөд уул уурхайн салбарт ажилладаг төрийн албан хаагчдын хувьд хувийн бизнесийн ашиг сонирхлын зөрчил оршоор байна.
- Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг бий болгосноор гарах үр дүнг уул уурхайн салбар болон төр засгийн түвшинд хангалттай ойлгодоггүй. Түүнчлэн ярилцлагад оролцсон зарим хүмүүсийн хувьд УИХ-ын гишүүд болон улс төрд нөлөө бүхий зарим хүмүүсийн хувийн ашиг сонирхол нь эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлийн хууль тогтоомжийг урагшлуулахад саад тотгор болж байна хэмээн үзжээ.

- Өргөн мэдүүлээд буй хэд хэдэн хуулийн төсөл ойрын үед хэлэлцэх асуудлын жагсаалтад багтана гэдэгт эргэлзэж байна. Хэд хэдэн оролцогчийн зүгээс Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хуулийн төсөл ойрын хугацаанд батлагдан, хэрэгжиж эхэлнэ гэдэгт эргэлзэж байсан ба Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлт энэ удаагийн эсвэл дараагийн нэгдсэн чуулганаар батлагдана гэсэн хүлээлт өндөр байна.
- Засгийн газрын зүгээс төрийн үйлчилгээг цахимжуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэх, улам хурдтай хэрэгжүүлэх шаардлагатай байна. Олон оролцогчдын зүгээс төрийн үйлчилгээг цахимжуулах чиглэлээр Засгийн газар нилээд хүчин чармайлт гаргаж буй талаар дурдсан. Гэвч хэрэгжилт нь удаашралтай буйд зарим хүмүүс бухимдаж буйгаа илэрхийлж байв. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлын хувьд цахимжуулах нь тухайн мэдээллийг онлайн хэлбэрээр цуглуулж, машинд уншигдах форматаар түгээх нь энэ чиглэлээр хийгдэх хамгийн том хувь нэмэр болох юм.
- Эцсийн өмчлөгчийн ил тод байдал нь хэрэгжилтийнхээ эхний шатанд л байна. Аж ахуйн нэгжүүдийн бүртгэлийн чиглэлээр ахиц дэвшил гарч буй ч мэдээллийг хянан баталгаажуулах, эцсийн өмчлөгчийн мэдээллийг ашиглахын үр өгөөжийн талаар мэдлэг бий болгоход бага төвлөрч байна. Тухайлбал, хянан баталгаажуулсан мэдээлэл нь эзэмшлийн мэдээллийг баталгаажуулах чиглэлээр хууль хяналтын байгууллагын зарцуулах нөөцийг хэмнэх хэмнэх юм.

#### 4.1 ОРОЛЦОГЧ ТАЛУУД, ОРОЛЦООНЫ ИРЭЭДҮЙН ЗУРАГЛАЛ

Тухайн оролцогч талууд, Засгийн газар, хууль тогтоох байгууллагын гишүүд, иргэний нийгэм болон бизнесийн салбарын оролцогч талууд нь Монгол улс дахь эцсийн өмчлөгчид хамаарах хууль, журмыг хэрэгжүүлэхэд тодорхой үүрэг гүйцэтгэж, Эцсийн өмчлөгчийн олон нийтэд ил тод бүртгэлийг бий болгох боломжтой юм. Доорх Хүснэгт 2-т өмнө нь бусад улс орнуудад ашиглаж байсан зарчмыг ашиглан гаргасан эцсийн өмчлөгчийн хэрэгжилтийн зураглалыг харууллаа. Эцсийн өмчлөгчийг ил тод тайлагнах чиглэлээр ажиллах байгууллага, хувь хүн ч эцсийн өмчлөгчийг тайлагнах чиглэлээр нэгээс с илүү тооны баганад багтаж болно. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахад ахиц дэвшил гарахын хэрээр оролцогч тал нэг бүрийн үүрэг рөл өөрчлөгдөж болно.

#### ХҮСНЭГТ 2: Оролцогч талуудын жишээ зураглал

Орчин бүрдүүлэгч	Амжилтын үр шим хүртэгч	Харилцаа холбоог хангагч
Эдгээр нь эцсийн өмчлөгчийн мэдээллийн ил тод байдлын мэдээллийн хүртээмжийн дизайныг гарган, хэрэгжүүлэх орчныг тодорхойлох хувь хүн, байгууллагууд юм. Үүнд олон нийтэд нээлттэй бүртгэлийг үүсгэж, хэрэгжүүлэхэд хамгийн их нөлөөлөл үзүүлэх болон хууль тогтоох, хэрэгжүүлэх үйл явцад үүрэг гүйцэтгэх оролцогч талуудыг багтаана.	Эдгээр нь эцсийн өмчлөгчийн үнэн зөв мэдээллийг олон нийтэд нээлттэй болсон үеэс эхлэн цаг тухайд нь шуурхай авч, үр өгөөжийг нь хүртэх байгууллага, хувь хүмүүс юм.	Эдгээр нь эцсийн өмчлөгч, үүний үр шимийн талаарх нийтлэг ойлголтын талаар мэдээлэл харилцааны үйл ажиллагааг явуулахад болон бусад талуудтай хийгдэх мэдээлэл харилцааг бэхжүүлэн сайжруулж өгөх хувь хүн, байгууллагууд юм.
ХЗДХЯ	ОУИТБС	ОУИТБС
УБЕГ	УУХҮЯ	УБЕГ
УИХ	АТГ	АТГ
АТГ	УБЕГ	ИНБ-ууд
Сангийн яам	Уул уурхайн компаниуд	Хэвлэл мэдээлэл
УУХҮЯ	Гадаадын хөрөнгө оруулагчид	
	Арилжааны банкнууд	



## 5. Хийдлийн шинжилгээ (Gap analyses)

Доорх хүснэгтэд эцсийн өмчлөгчтэй холбоотой Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын сайн жишээ хоорондын хийдэл, зөрүүтэй байдлыг тогтоон харуулсан.

**ХҮСНЭГТ 3: Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал болон олон улсын сайн туршлагад хийсэн хийдлийн шинжилгээ**

Эцсийн өмчлөгчийн элементүүд	Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал	Олон улсын сайн туршлага	Хийдлийг арилгах боломжит арга хэмжээ
Эцсийн өмчлөгчийн тодорхойлолт	Хуульд 3 өөр тодорхойлолт тусгагдсан	Бүх аж ахуйн нэгжид нэг тодорхойлолт баримталдаг	Одоогийн тодорхойлолтуудын нэгийг ашиглах, эсвэл Одоогийн бүх тодорхойлолтыг орлох нэг тодорхойлолтыг хуулиар тогтоох
Босго	Тодорхойлолт нэг бүр нь ялгаатай босго хувь заасан ба жишээ нь банкны хуульд 5%, мөнгө угаахтай тэмцэх тухай хуульд 33%, татварын ерөнхий хуульд 30%. Мөн ОУИТБС нь 5%-ийн босго заадаг.	Хамгийн түгээмэл босго хувь нь 25% (ФАТФ болон ЕХ-ны зөвлөмжөөр) байдаг ч хэд хэдэн улс сүүлийн үед үүнээс доогуур хувийг хуульдаа заан оруулсан. ОУИТБС-ын Стандартаар 5-25%-ийн хооронд тогтоохыг зөвлөдөг.	Одоогийн тодорхойлолтыг шинэчлэн +25% тогтоосон буй босгыг доошуулах, эсвэл дээд тал нь 25 эсвэл доогуур хувийн босгыг тогтоох.
Цуглуулсан мэдээлэл	УБЕГ-ын зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээлэл гаргуулан авахад ашиглаж буй маягт нь эцсийн өмчлөгч нэг бүрийг тогтоох, тэдний эзэмшлийн нөхцөл байдал, шинж чанар, цар хүрээг тогтоох, тэдэнтэй холбоо тогтоохуйц боломжтой хэмжээнд хангалттай мэдээлэл шаардах	Олон улсын сайн туршлага нь эцсийн өмчлөгч нэг бүрийг нэг бүрчлэн тогтоох, тэдний эзэмшлийн нөхцөл байдал, шинж чанар, цар хүрээг тогтоох, тэдэнтэй холбоо тогтоохуйц хэмжээний хангалттай мэдээллийг шаардан тайлагнуулах	Одоогоор Монгол улс нь олон улсын сайн туршлагад нийцэж буй хэдий ч салбар бүрийн хувьд эцсийн өмчлөгчийн мэдээллийг цуглуулах байдал харилцан адилгүй байна. Тиймээс тэрхүү мэдээллийг нэгтгэх шаардлагатай ба УБЕГ нь энэхүү үүргийг хэрэгжүүлэх боломжтой.
Мэдээллийг олон нийтэд ил тод болгох	Хуулийн этгээд нэг бүрийн суурь мэдээлэл нээлттэй ч эцсийн өмчлөгчийн мэдээлэл хаалттай байна	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл олон нийтэд нээлттэй, жишээ нь ЕХ-ны Мөнгө угаахтай тэмцэх журмын дагуу	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл авах эрхийг шууд заан өгсөн Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийг батлуулан, хэрэгжүүлж, олон нийтэд нээлттэй эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хөгжүүлэн, бий болгон, ажиллуулах Эцсийн өмчлөгчийн мэдээллийг хүртээмжтэй болгоход саад болж буй аливаа хуулийн заалтуудыг тодорхойлж, зөрчлийг арилгах
Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд эцсийн өмчлөгчийг тайлагнах үүрэгтэй	Хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд тайлагнах тухай тусгайлсан шаардлага байхгүй	Бүртгэлтэй компаниудад гардаг асуудлуудыг тогтоохын тулд тайлагнах шаардлагыг тусгайлан тавьдаг	Хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй компаниудад тусгайлсан шаардлага тавих
Төрийн өмчит компаниуд эцсийн өмчлөгчийн тайлан гаргах шаардлага	Төрийн өмчит компаниудад эцсийн өмчлөгчийн тайлан гаргах шаардлага тусгайлан тавиагүй	Төрийн өмчит компаниуд эцсийн өмчлөгчийн тайлан гаргах шаардлага тавих нь хамаарах хувь хүн байхгүй байхыг хүлээн зөвшөөрөх	Төрийн өмчит компаниудад тусгайлан тайлан гаргах шаардлага тавих
Улс төрд нөлөө бүхий этгээдүүд тайлагнах шаардлага	Монгол улсын төрийн өндөр албан тушаалтнууд жил тутам өөрийн хөрөнгө орлогын мэдүүлэг гаргах үүрэг хүлээдэг. Монгол улсад бүртгэлтэй компанийн эцсийн эзэмшигч гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээдийг тодорхойлох үйл явц явагддаггүй	Аж ахуйн нэгжийн эцсийн өмчлөгч болох дотоод болон гадаадын улс төрд нөлөө бүхий этгээдийг ил тод тайлагнах байх тусгайлсан шаардлага бий болгох.	өмчлөгчийн бүртгэлийг харилцан уялдаатай ажиллуулж, харилцан хяхан баталгаажуулалтад ашиглах, болон эцсийн өмчлөгч болох гадаад улсын иргэн улс төрд нөлөө бүхий этгээдийг ил тод тайлагнах шаардлага тавих.

Эцсийн өмчлөгчийн элементүүд	Монгол улсын өнөөгийн нөхцөл байдал	Олон улсын сайн туршлага	Хийдлийг арилгах боломжит арга хэмжээ
Хянан баталгаажуулалт	Хянан баталгаажуулах ямар арга хэмжээг хэрэгжүүлж буй нь тодорхойгүй	Хянан баталгаажуулах олон төрлийн арга хэмжээ, эцсийн өмчлөгчийг тайлагнах, мэдээлэл хадгалах, нээлттэй болгох олон үе шат нь мэдээлэл нь үнэн зөв, шинэ болохыг баталгаажуулна	Хянан баталгаажуулах зөв зохистой арга хэмжээг хэрэгжүүлж байх.
Мэдээлэлд боловсруулалт хийх <sup>5</sup>	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл нь нийтэд ил тод бус тул ямар нэгэн байдлаар боловсруулалт хийгдэхгүй	Нийтэд нээлттэй эцсийн өмчлөгчийн мэдээллийн хувьд үүнээс үүдэн хувийн аюулгүй байдалд нь аюул учирч буй нь тогтоогдох тохиолдолд тухайн мэдээллийг нийтэд нээлттэй бүртгэл дээр өөрчлөх үйл явц, боломж нээлттэй байх	Эцсийн өмчлөгчийн мэдээлэл олон нийтэд нээлттэй болохоос өмнө хэрхэн өөрчлөх, үл харуулах үйл явцыг төлөвлөн бэлтгэсэн байх. Ингэхдээ бодит аюул учрах гэдгийг хэрхэн тодорхойлох талаар Эрүүгийн хуультай уялдсан нарийн чиглэл гаргах
Оролцогч талуудын оролцоо	Төрийн зүгээс эцсийн өмчлөгчийн мэдээллийн ач холбогдлын талаар агентлаг хоорондын болон хувийн хэвшилтэй хамтран ажиллах, оролцоог хангах талаар дутмаг	Компаниудыг оролцуулан эцсийн өмчлөгчийн бүртгэлийн хэрэгцээ, хэрхэн даган мөрдөх, даган мөрдөөгүйгээс үүдэх үр дагавар, олон нийтэд нээлттэй мэдээллийг хэрхэн ашиглах талаар тайлбарлах	Хувийн хэвшил болон хамаарах төрийн байгууллагатай хамтран стратегийн хамтын ажиллагаа, оролцооны кампанит ажлыг төлөвлөн хэрэгжүүлэх

<sup>5</sup> Мэдээлэлд редакц хийх үйл явц нь Монголын эцсийн өмчлөгч нарт таатай нөхцөл олгох боломжийг бүрдүүлж болзошгүй хэмээн эмээж буйгаа хянан тохиолдуулсан нэг зөвлөхийн зүгээс илэрхийлж байсан юм. Гэхдээ хувь хүний аюулгүй байдалд эрсдэлд учруулах нөхцөл байдал үүсгэхгүйн тулд энэхүү процессийг бий болгох нь чухал. ИБУИНВУ-ын хувьд аюулгүй байдлын эрсдэлт нөхцөл үүссэнийг заавал цагдаагаас баталгаажуулах шаардлага тавьдаг.

## 6. Зөвлөмжүүд

Хийж гүйцэтгэсэн судалгаа, оролцогч талуудтай зохион байгуулсан ярилцлага, болон олон улсын сайн туршлагын талаарх мэдлэг ойлголтдоо тулгуурлан судалгааны багийн зүгээс дараах зөвлөмжийг санал болгож байна. Үүнд:

- 1. Манлайлагч тодорхойлох:** Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах үйл явцыг удирдан жолоодох манлайлагчийг тодорхойлох шаардлагатай байна. Тухайн хүн нь эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр шийдвэр гаргах түвшинд нөлөөлөх эрх мэдэл, нэр хүндтэй байх шаардлагатай юм. Ингэснээр шаардагдаж буй шинэчлэлийг (эцсийн өмчлөгчийн чиглэлээр гарсан хууль тогтоомж, эрх зүйн актыг сайжруулах гэх мэт) удирдан оролцохын сацуу, мэдээллийг цахимжуулах зэрэг практик арга хэмжээг хэрэгжүүлэх нөөц бололцоог (УИХ-аар хэлэлцэх асуудалд багтаахын тулд лобби хийх гэх мэт) бүрдүүлнэ. Эдгээр хүчин зүйлийг харгалзан үзвэл тэрхүү манлайлагч нь Засгийн газар (сайд эсвэл сайд асан), хууль тогтоох байгууллагад ажиллаж байсан туршлагатай хүн, иргэний нийгмийн байгууллагын удирдагч эсвэл бизнесийн салбарын манлайлагч (жишээ нь уул уурхайн салбарын) байх нь зүйтэй. Иргэний нийгмийн байгууллагууд, хууль тогтоогчид, ОУИТБС-ын ОТОБ-ын гишүүд болон бизнесийн салбарынхан хамтраад ийм манлайлагчийг тодорхойлж, цаашид энэхүү үйл явцыг урагшлуулахад нь дэмжлэг үзүүлэх шаардлагатай.
- 2. Техникийн туслалцаа үзүүлэх дэмжлэг, санхүүжилтийг олох:** Дээр дурдсан талуудын төлөөлөл буюу иргэний нийгмийн байгууллагууд, хууль тогтоогчид, ОУИТБС-ын ОТОБ-ийн гишүүд болон бизнесийн салбарын манлайлагчид эвсэж Эцсийн өмчлөгчийг бүртгэх, мэдээлэл цуглуулах ажлыг цахимжуулахад нь техникийн туслалцаа үзүүлж, санхүүжүүлэх боломжтой олон улсын байгууллагуудыг тодорхойлох хэрэгтэй байна. Мөн уг эвсэл нь Монгол улсын Засгийн газарт хандан техникийн туслалцаа авах хүсэлт гаргуулах нөлөөллийн ажлыг хийх шаардлагатай юм. Техникийн туслалцаа үзүүлэх боломжтой байгууллагуудын хувьд бүс нутгийн хөгжлийн банк (АХБ, ЕСБХБ гэх мэт), олон улсын байгууллага (ЕХ гэх мэт) болон хоёр талын хандивлагч улс орнууд дангаараа болон хамтран оролцох боломжтой. Энэхүү дэмжлэгийн хүрээнд олон нийтэд нээлттэй эцсийн өмчлөгчийн бүртгэлийг хөгжүүлэх, хэрэгжүүлэхэд санхүүжилт болон бусад төрлийн туслалцаа үзүүлэх юм. Уг боломжийг бүрдүүлж чадвал Монгол улсад бизнесийн таатай орчин бүрдүүлэх, ялангуяа уул уурхайн салбарт авлигыг бууруулахад томоохон хувь нэмэр оруулах юм.
- 3. Олон-талт/агентлаг хоорондын ажлын хэсэг байгуулах:** Засгийн газраас олон нийтэд нээлттэй хэлбэр бүхий эцсийн өмчлөгчийн мэдээллийн санг бүрдүүлэх, үйл ажиллагаанд нь хяналт тавих чиг үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах нь зүйтэй. Энэхүү ажлын хэсэгт эцсийн өмчлөгчийн бүртгэлийн систем хөгжүүлэх, удирдан ажиллах, хэрэгжүүлэх, ашиглах үйл явцад оролцох төрийн байгууллагуудын бүх төлөөллийг багтаасан байх хэрэгтэй. Ажлын хэсэг нь бүртгэлийн үйл ажиллагааны стратегийн чиглэлийг тодорхойлохоос гадна хөгжүүлэлт, хэрэгжилтийн чиглэлээр бодит шийдвэр гаргах юм. Ажлын хэсэг нь мөн хувийн хэвшил болон иргэний нийгмийн байгууллагуудтай тогтмол уялдааг хангах үүрэг хүлээхээс гадна эцсийн өмчлөгчийн ил тод байдлын тогтолцооны үр дүнтэй байдлыг илтгэн харуулахад чухал үүрэг гүйцэтгэнэ.
- 4. Иргэний нийгмийн байгууллагын хяналтыг бий болгох:** Иргэний нийгмийн байгууллагуудын зүгээс Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухайн хуулийн нэмэлт өөрчлөлтийг батлах үйл явц, цаашдын хэрэгжилтэд мониторинг хийж, эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах чиглэлээр эерэг өөрчлөлт гарч буй эсэхийг баталгаажуулах шаардлагатай. Хийгдэх мониторингийн хувьд эцсийн өмчлөгчийн мэдээллийг авах олон нийтийн эрхийг хуулиар хангасан байдал, мэдээлэлд хандах боломж бодитоор бүрдсэн эсэхэд хяналт тавих хэлбэрээр хэрэгжинэ. Мөн тухайн арга хэмжээг хэрэгжүүлэхэд нь иргэний нийгмийн байгууллагын зүгээс засгийн газарт холбогдох дэмжлэгийг үзүүлэн ажиллах юм.

- 5. Тодорхойлолтыг нэг болгох:** Монгол улсын Засгийн газрын зүгээс эцсийн өмчлөгчийн тухай олон тодорхойлолтоос нэгийг нь сонгон цаашид жигд хэрэглэж хэвших шаардлагатай байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуульд заасан тодорхойлолтыг УБЕГ эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэхэд ашиглаж буй тул энэхүү тодорхойлолтыг сонгон цаашид нэг мөр хэрэглэж болох юм. Ийнхүү хэрэглэснээр банк зэрэг тухайлсан салбарт одоо ашиглаж буй тодорхойлолтыг цаашид хэрэглэхээ болино гэсэн үг биш. Ер нь Монгол улсын Засгийн газраас цаашид олон улсын сайн туршлагад нийцсэн нэг тодорхойлолтыг хуульчилж, эцсийн өмчлөгч тайлагнах шаардлагатай өмчлөлийн доод хувийг 25%-аас хэтрүүлэлгүй тогтоох шаардлагатай. Харин энэ хооронд хууль тогтоомжид одоо байгаа тодорхойлолтууд дахь босгыг 25%-иас бууруулах боломжийг судлан үзэх шаардлагатай байна. Олон улсын шаардлагад нийцэх эцсийн өмчлөгчийн тодорхойлолтын жишээг Хавсралт 2-оос үзнэ үү.
- 6. Эцсийн өмчлөгчийг тайлагнах болон редакц хийх шаардлагыг тодорхой болгох:** Эцсийн өмчлөгчийн мэдээллийг олон нийтэд нээлттэй болгохыг хуульчлахын зэрэгцээ Монгол улсын Засгийн газрын зүгээс хөрөнгийн биржид бүртгэлтэй компаниуд, төрийн өмчит компаниуд болон гадаад улсын улс төрд нөлөө бүхий этгээдэд эцсийн өмчлөгчөө тайлагнах тусгайлсан шаардлагыг тавих хэрэгтэй. Суурь хууль тогтоомжоор зохицуулах зайлшгүй шаардлага үүсээгүй л бол үүнийг холбогдох журмаар зохицуулах боломжтой. Мөн эцсийн өмчлөгчийн мэдээллийг нийтэд ил болгосноос үүдэн хувийн аюулгүй байдал нь хөндөгдөж буй талаар нотолгоотой хүсэлт ирүүлсэн тохиолдолд хувийн мэдээлэлд өөрчлөлт оруулах (редакц хийх) хүсэлтийг хувь хүмүүсийн зүгээс гаргах үйл явцыг хууль тогтоомжоор зохицуулж өгөх шаардлагатай. Өөрчлөлт оруулах хүсэлт гаргах үндэслэлийг нарийн тогтоохын зэрэгцээ хүсэлтийг зөвшөөрөөгүй тохиолдолд гомдол гаргах, давж заалдах боломжтой байх ёстой.
- 7. Бүртгэлийн уялдааг хангах:** АТГ болон УБЕГ нь нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлгийн бүртгэл болон эцсийн өмчлөгчийн бүртгэлийг харилцан уялдуулах чиглэлээр бодлогын түвшинд хамтран ажиллах шаардлагатай. Өөрөөр хэлбэл энэхүү хоёр байгууллагад хадгалагдаж байгаа мэдээллийг харилцан солилцож, баталгаажуулснаар үйл ажиллагааны үр ашиг болон мэдээллийн үнэн зөв байдал нэмэгдэнэ. Түүнчлэн, тухайн бүртгэлийн сангуудад буй мэдээллийг зөрүүг шалган нягталж, шаардлагатай тохиолдолд холбогдох талуудаас тодруулга авах нөхцлийг бүрдүүлэх нь зүйтэй. Эцсийн өмчлөгчийн бүртгэлийг нийтэд ил болгохдоо хоёр байгууллага нь мэдээллийн форматыг хүртэл нэгтгэн ижилсүүлэх шаардлага үүснэ.
- 8. Хянан баталгаажуулах стратегийг хэрэгжүүлэх:** УБЕГ нь өөрт цуглуулсан мэдээллийн үнэн зөв байдлыг хянан баталгаажуулах чиглэлээр стратеги боловсруулан, хэрэгжүүлэх шаардлагатай. Хянан баталгаажуулалтад баримтлах стратегийн арга хандлагын тоймыг Хавсралт 4-т харуулсан.
- 9. Хөрөнгө орлогын мэдүүлэгт буй мэдээллийг хянан баталгаажуулах:** АТГ нь нийтийн албан хаагчдын хөрөнгө орлогын мэдүүлэгт буй мэдээллийг хянан баталгаажуулах чиглэлээр стратеги хэрэгжүүлэх шаардлагатай (Хавсралт 4).
- 10. Стратегийн мэдээлэл харилцааны кампанит ажил хэрэгжүүлэх:** УБЕГ нь эцсийн өмчлөгчийн мэдээлэл, үүнийг олон нийтэд ил болгохын давуу талуудыг онцолсон стратегийн мэдээлэл харилцааны кампанит ажлыг төлөвлөн, хэрэгжүүлэх шаардлагатай. Энэхүү кампанит ажил нь холбоотой талуудыг тодорхойлсноор эхлэх бөгөөд эцсийн өмчлөгчөө тайлагнах үүрэг хүлээсэн компаниуд болон бусад аж ахуйн нэгжүүд, мэдээлэлд хандах талууд, олон нийтэд чиглэн хэрэгжинэ. Уг ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлж болох ба эхний шатанд эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах шалтгаан, эрх зүйн үндсийг тайлбарлах, хэрхэн даган мөрдөх чиглэлээр зөвлөгөө өгөх, хэрэгжүүлээгүй тохиолдолд үүдэн гарах үр дагаврыг ойлгуулах зэрэг багтана. Харин эцсийн өмчлөгчийн бүртгэл нээлттэй болсон үед мэдээлэл хэрхэн авах, зөрүүтэй мэдээллийг хэрхэн мэдээлэх, мэдээлэлд хандсанаар үүсэх үр ашгийн талаар танилцуулга хийж болно. УБЕГ нь энэхүү ажлын хүрээнд тухайлсан хэрэглэгч нар буюу уул уурхайн компани, орон нутгийн иргэдэд тусгайлсан заавар, зөвлөгөөг өгөх боломжтой.

## 7. Хавсралтууд

---

### ХАВСРАЛТ 1: ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХИЙСЭН ЯРИЛЦЛАГА, АСУУЛГА

Энэхүү тайланг бэлтгэхэд судалгааны баг нь доор дурдсан байгууллагуудын төлөөлөлтэй ярилцлага хийлээ:

**Америкийн худалдааны танхим (AmCham)**

**Азийн хөгжлийн банк (АХБ)**

**Европын сэргээн босголт, хөгжлийн банк (ЕСБХБ)**

**Монголын олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын санаачилга (ОУИТБС)**

**Авлигатай тэмцэх газар (АТГ)**

**Сангийн яам**

**Монгол Банк**

**Байгалийн баялгийн засаглалын хүрээлэн**

**Нээлттэй нийгэм форум**

**ОТ ажиглагч**

**Хөгжлийн төлөөх судалгаа (R4D) хөтөлбөр**

**Транспаренси Интернейшнл Монгол**

**ИБУИНВУ-ын ЭСЯ**

**АНУ-ын ЭСЯ**

Энэхүү ярилцлагад зориулан ярилцлагын бүтцийг хангах зорилгоор доорх асуулгыг ашигласан:

## ОРОЛЦОГЧ ТАЛУУДАЙ ХИЙХ ЯРИЛЦЛАГЫН АСУУЛТУУД

1. Монгол улс дахь эцсийн өмчлөгчийн асуудлаар та бүхэн ямар оролцоотой байдаг/байсан бэ?
2. Монгол улс дахь компани, аж ахуйн нэгжийн бүртгэлийн үйл явцын талаар ямар ойлголттой вэ? Шинээр аж ахуйн нэгж байгуулахад онлайн хэлбэрээр бүртгүүлэх боломжтой юу? Аж ахуйн нэгжийн бүртгэлийн мэдээлэл олон нийтэд нээлттэй байдаг уу? Мэдээллийн үнэн бодит байдлыг баталгаажуулах байнгын (жишээ нь жил тутмын) үйл явц хийгддэг үү?
3. Монгол улсад бүртгэлтэй аж ахуйн нэгжүүд нь өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг бүртгэлийн байгууллагад гарган өгөх хуулийн шаардлагын талаар та ямар ойлголттой байна вэ?
4. Өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох үүргийг компани, аж ахуйн нэгжүүдэд ноогдуулж буй хуулийн ямар төслийн талаар та мэдэж буй вэ?
5. Монгол улс дахь хууль тогтоох үйл явцын талаар танд ямар ойлголт байгаа вэ? Эцэслэн батлагдахын тулд хуулийн төсөл нь ямар үе шатуудыг дамжих ёстой вэ?
6. Өнөө Монгол улсад ашиглаж буй эцсийн өмчлөгчийн талаар та ямар ойлголттой байна вэ?
7. Өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох хуулиар хүлээсэн үүргийг компани, аж ахуйн нэгжүүдэд ноогдуулах чиглэлээр ажиллаж буй ямар санаачилгын талаар та мэдэх вэ? Эдгээр санаачилгуудаас ямар сургамж авах ёстой гэж та үзэж байна вэ?
8. Өнөөг хүртэл энэ чиглэлд ямар ахиц гарсан гэж та бодож байна вэ?
9. Өөрийн эцсийн өмчлөгчийн мэдээллийг ил тод болгох үүргийг компани, аж ахуйн нэгжүүдэд ноогдуулахад ямар саад тотгорууд учирч байна гэж та харж байна вэ?
10. Эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг ямар байгууллага, төрийн байгууллага дэмждэг гэж та үзэж байна вэ? Ямар байгууллага, төрийн байгууллага эргэлзэж эсвэл эсэргүүцэж буй вэ? Ямар шалтгааны улмаас тэд эсэргүүцэж байна вэ?
11. Эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр хувийн хэвшлийн компаниуд ямар байр суурь илэрхийлж байна вэ?
12. Дараах ангилал нэг бүр дээр ил тод болгон тайлагнах тусгай шаардлагууд байх хэрэгтэй гэж та бодож байна уу:
  - a. Хөрөнгийн бирж (жишээ нь Лондоны хөрөнгийн бирж гэх мэт) дээр бүртгэл бүхий компаниудын эцсийн байдлаар эзэмшиж буй компани, аж ахуйн нэгжүүд,
  - b. Төрийн өмчит компаниуд,
  - c. Улс төрд нөлөө бүхий хүмүүс,
  - d. Бусад ангилал?
13. Эцсийн өмчлөгчийн ил тод байдал ямар үр өгөөж авчирна гэж та итгэж байна вэ? Хамгийн том хэрэглэгч нь ямар төрлийн байгууллагууд байна гэж та үзэж байна вэ?
14. Өөрийн хөрөнгө болон аж ахуйн нэгжид эзэмшиж буй хувь хэмжээг мэдүүлэх чиглэлээр төрийн өндөр тушаалтнуудад (жишээ нь УИХ-ын гишүүд, Засгийн газрын гишүү, төрийн бусад өндөр албан тушаалтан) ноогдуулаад буй үүргийн талаар та ямар зүйлийг мэдэх вэ?
15. Монгол улсын эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангахад бусад ямар хүчин зүйл чухал ач холбогдолтой гэж та бодож байна вэ?

## ХАВСРАЛТ 2: ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ЖИШЭЭ

Хуулийн этгээд эсвэл хуулийн дагуу үүссэн зохион байгуулалтын бүтцийн “Эцсийн өмчлөгч” гэдэг нь тухайн этгээд, бүтцийг шууд эсвэл шууд бус байдлаар эзэмших эсвэл хяналтаа байлгах замаар эзэмшиж, хянаж буй хувь хүнийг хэлнэ.

Энэхүү тодорхойлолтод дараах шалгуурт шууд эсвэл шууд бусаар нийцэх хувь хүнийг хамруулна:

- a. Хуулийн этгээдийн хувьцаа эсвэл саналын эрхийн 25 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсвэл хянадаг; эсвэл
- b. Хувь хүн нь улс төрд нөлөө бүхий этгээд бөгөөд тухайн хувь хүн нь хуулийн этгээдийн хувьцаа эсвэл саналын эрхийн 5 болон түүнээс дээш хувийг эзэмшдэг эсвэл хянадаг; эсвэл
- c. Хуулийн этгээд эсвэл зохион байгуулалтын бүтцийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд эсвэл ижил төстэй бүтцийн олонхыг томилох, хориг тавих эсвэл чөлөөлөх эрх бүхий; эсвэл
- d. Дээрх а) - с) нөхцөл хамаарахгүй тохиолдолд доорх бүтцэд томоохон нөлөө бүхий эсвэл хяналтдаа байлгадаг эсвэл эдийн засгийн үр шимийг хүртэх эрх бүхий эсвэл эрхийг бодитоор эдэлж буй,
  - a. Хуулийн этгээд эсвэл зохион байгуулалтын бүтцээс; эсвэл
  - b. Хуулийн этгээд бус траст эсвэл фирм, гэхдээ а) - с) ангилалд нийцэж буй;

дээрх тохиолдолд тухайн хувь хүнийг хуулийн этгээд эсвэл хуулийн хүрээний зохион байгуулалтын бүтцийг “эзэмшдэг эсвэл хянадаг” хэмээн үзнэ.

- e. Эргэлзээ бүхий ойлголтоос зайлсхийх зорилгоор агент, нэр дэвшсэн этгээд, итгэмжлэгдсэн этгээд болон бусад дундын зуучлагч нарыг эцсийн өмчлөгч хэмээн үзэхгүй.
- f. Хамтарсан аж ахуйн нэгжийн хувьд үүнд хамаарах аж ахуйн нэгж нэг бүр нь өөрийн эцсийн өмчлөгчийг ил тод болгоно.

“Хувь хүн” хэмээн шаардлагаас чөлөөлөгдөх нөхцөл:

Хэрэв төр эсвэл төрийн байгууллагыг хувь хүний нэгэн адил эцсийн өмчлөгч хэмээн үзэх тохиолдолд дээрх 1 дүгээр заалтад заасны дагуу ЗГ эсвэл төрийн байгууллага нь эцсийн өмчлөгч хэмээн тооцогдоно.

## ХАВСРАЛТ 3: УЛС ТӨРД НӨЛӨӨ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН ТОДОРХОЙЛОЛТЫН ЖИШЭЭ

- a. Улс төрд нөлөө бүхий этгээд’ гэж төрийн өндөр албан тушаалд алба хашихаар томилогдсон эсвэл томилогдоод буй хувь хүнийг хэлэх ба энэхүү тодорхойлолтод доорх болон эдгээрээр үл хязгаарлагдах бусад этгээд, тэдний гэр бүлийн гишүүд болон ойрын хамааралтай хүмүүсийг багтаана:
  - a. Төрийн тэргүүн, Засгийн газрын тэргүүн, Засгийн газрын гишүүд, дэд сайд;
  - b. Парламент эсвэл ижил төстэй хууль тогтоох байгууллагын гишүүд;
  - c. Улс төрийн намын удирдах байгууллагын гишүүд;
  - d. Гаргаж буй шийдвэрийг нь онцгой нөхцөл үүсэхээс нааш давж заалдах боломжгүй Дээд шүүх, Үндсэн хуулийн шүүх болон бусад дээд шатны шүүх эрх мэдлийн байгууллагуудын шүүгч, гишүүд;
  - e. Аудитын газар эсвэл төв банкны удирдах зөвлөлийн гишүүд;
  - f. Элчин сайдууд, хэргийг түр хамаарагчид болон зэвсэгт хүчний дээд тушаалтнууд;
  - g. Төрийн өмчит үйлдвэрийн газруудын захиргаа, удирдлага эсвэл хяналтын бүтцийн гишүүд;
  - h. Олон улсын байгууллагын захирал, дэд захирал, удирдах зөвлөлийн гишүүд болон тэдэнтэй жиших албан тушаалтан.

(a) - (h) хэсэгт заагдсан төрийн албан тушаал нь дунд болон доод шатны албан хаагчдыг хамруулна хэмээн үзэхгүй.

- b. аалт 3 дээрх гэр бүлийн гишүүн гэдэгт доорхыг багтаана:
  - Улс төрд нөлөө бүхий этгээдийн гэр бүлийн гишүүн эсвэл үүнтэй ижил төстөйд тооцогдох этгээд;
  - Улс төрд нөлөө бүхий этгээдийн эгч, ах дүүс болон тэдний гэр бүл, энхэр, нөхөр, эсвэл эдгээртэй адилтгах хүмүүс, тухайн холбоо нь төрмөл, өргөмөл эсвэл бусад хэлбэрээс үл хамааран;
  - улс төрд нөлөө бүхий этгээдийн эцэг эх, эмээ өвөө;

**‘ойрын хамаарал бүхий этгээд’ гэдэгт доорхыг багтаана:**

- улс төрд нөлөө бүхий этгээдтэй хамтарсан хуулийн этгээд этгээд хуулийн дагуух бүтцийн хамтран эзэмшигч хувь хүн эсвэл бизнесийн ойрын харилцаа бүхий хувь хүн;
- улс төрд нөлөө бүхий этгээдэд де факто өгөөж өгөхөөр байгуулагдсан нь тодорхой буй хуулийн этгээдийг дангаар эзэмшиж буй хувь хүн.

#### ХАВСРАЛТ 4: БАТАЛГААЖУУЛАЛТЫН СТРАТЕГИЙН АРГА ХАНДЛАГА

Стратегийн арга хандлагад дараах багтах ёстой:

- Мэдээлэл өгөх явцад хянан баталгаажуулалт,
- Мэдээллийг авах, ашиглах үеийн хянан баталгаажуулалт,
- Мэдээллийн хүртээмжийг хангах замаар хянан баталгаажуулах,
- Мэдээлэл харилцан солилцох замаар хянан баталгаажуулалт хийх.

Жишээ нь мэдээлэл оруулах хэсэг нь эхлээд эцсийн өмчлөгчийн мэдээллийг оруулан, улмаар цаашид өөрчлөлт гарсан, дахин баталгаажуулах шаардлагатайг сануулж байх. Үүнд хамаарах арга хэмжээнд дараах багтаж болно:

- Урьдчилан бэлдсэн цэс (drop-down menu),
- Заавал мэдээлэл оруулах талбар,
- Стандартын дагуу хөрвүүлэн галиглах арга,
- Хамрах огноо шалгах,
- Дэмжих/дагалдах баримт бичгүүд.

Баталгаажуулах үйл явцын хоёр дугаар хэсэг нь мэдээлэл гарган өгсний дараа хийгдэнэ. Үүнд дараах багтаж болно:

- Анхаарах асуудлууд буюу Улаан дарцаг тодорхойлох,
- Эцсийн өмчлөгчийн мэдээллийг Засгийн газрын болон олон улсын мэдээллийн сантай, жишээ нь хоригт орсон компаниудын жагсаалт, хорио тавигдсан удирдлагын жагсаалт болон бусад мэдээллийн сантай харьцуулан шинжлэх,
- Төлөөлөх эсвэл санамсаргүй байдлаар түүвэрлэн авч, газар дээр нь шалгалт хийх,
- Тодорхой харагдаж буй зөрүү эсвэл эзэмшлийн хэв шинжийн талаарх сэжигтэй байдлыг мөрдөн шалгах.

Эцсийн өмчлөгчийн мэдээллийн хүртээмж болон харилцан солилцоонд хамаарах хянан баталгаажуулах механизмын хувьд эдгээр нь юуны өмнө хэрэглэгчид тухайн мэдээлэлд буй зөрүүтэй байдлыг тайлагнан мэдээлэхтэй хамааралтай байх бол бүртгэл болон гуравдагч талууд хоорондын бусад хамтын ажиллагаа нь зөв, алдаатай эсвэл дутуу мэдээлэл олж тогтоох, засварлах зэрэг багтана.

Хянан баталгаажуулалтад ашиглах шалгуур үзүүлэлтэд дараах багтана:

- Хэт ээдрээ бүхий эзэмшил/хяналтын бүтэц,
- Гадаад улсад бүртгэлтэй хуулийн этгээд эсвэл хувь хүн, ялангуяа ФАТФ болон ЕХ-ны жагсаалтад орсон эсвэл Монгол улсын зүгээс эрсдэл өндөртэй хэмээн үнэлсэн улсуудад бүртгэлтэй хуулийн этгээд, хувь хүнд хамаарах эзэмшил/хяналт,
- Хуулийн этгээд эсвэл хувь хүний эрүүгийн гэмт хэргийн түүх, ялангуяа мөнгө угаалт, терроризмыг санхүүжүүлэх, татвараас зайлсхийх, залилан, авлигын хэрэгт холбогдсон түүх,
- Олон улсын эсвэл дотоодын хоригийн жагсаалт эсвэл хамаарах мэдээллийн санд орсон эсэх,
- Хуулийн этгээд байгуулах эсвэл эзэмшил/хяналтаа өөрчилж буй сэжигтэй үйл ажиллагаа.



## 8. Ном зүй

---

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ТОГТООМЖ, ХУУЛИЙН ТӨСЛҮҮД

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, 2013  
<https://www.legalinfo.mn/law/details/9242>.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль, 2018  
<https://www.legalinfo.mn/law/details/13591?lawid=13591>

Банкны тухай хууль, 2010 <https://www.legalinfo.mn/law/details/108?lawid=108>..

Татварын ерөнхий хууль, 2019 <https://www.legalinfo.mn/law/details/14403?lawid=14403>.

Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, 2013 <https://www.legalinfo.mn/law/details/9243?lawid=9243>.

Олборлох үйлдвэрлэлийн салбарын ил тод байдлын тухай хуулийн төсөл  
<https://www.mmhi.gov.mn/uploads/file/7cda88633b6ba374d8dd944eeb20bcb90f8e0dfc.pdf>.

Мэдээллийн эрх чөлөө, мэдээлэл авах эрхийн тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн төсөл, 2020

### ОҮИТБС-ЫН БАРИМТ БИЧГҮҮД

ОҮИТБС-ын стандарт, 2019, голлон Шаардлага 2.5

ОҮИТБС-ын бодлогын баримт бичиг “Эцсийн өмчлөгчтэй хамаарах шаардлагын хэрэгжилтэд үнэлгээ хийх нь”, 2019 оны 07 сар, <https://eiti.org/document/assessing-implementation-of-eitis-beneficial-ownership-requirement>

ОҮИТБС-ын бодлогын баримт бичиг “ОҮИТБС-ын улс орнуудад эцсийн өмчлөгчийн ил тод байдлыг хангах эрх зүйн хандлага” 2019 оны 06 сар, [https://eiti.org/files/documents/legal\\_approaches\\_to\\_beneficial\\_ownership\\_transparency\\_in\\_eiti\\_countries.pdf](https://eiti.org/files/documents/legal_approaches_to_beneficial_ownership_transparency_in_eiti_countries.pdf)

ОҮИТБС-ын зүгээс эцсийн өмчлөгчийн чиглэлээр гаргасан зааварчилгаа 22, 2016 оны 05 сар, <https://eiti.org/GN22>.

Монголын ОҮИТБС-ын эцсийн өмчлөгчийг ил тод болгох замын зураг, 2016 оны 12 сар, <https://eiti.org/document/mongolia-beneficial-ownership-roadmap>

Монголын ОҮИТБС-ын 2019 оны тайлан, 2020 оны 12 дугаар сар хэвлэгдсэн, <https://eiti.org/document/mongolia-2019-eiti-report>

Нигер улсын 2019 оны Газрын тос, байгалийн хийх аудит болон 2020 оны Хатуу ашигт малтмалын аудитад ашигласан эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах маягт

Тринадад Тобаго улсын ОУИТБС-ын хийсэн эцсийн өмчлөгчийн хийдлийн шинжилгээ, шинэчилсэн бүртгэл, 2018 он, М.Баррон & Т.Лоу

Этиоп улсын ОУИТБС-ын хийсэн эцсийн өмчлөгчийн цар хүрээ тогтоох судалгаа, 2017 оны 03 сар, <https://eiti.org/document/ethiopia-beneficial-ownership-scoping-study>.

## ФАТФ-ЫН БАРИМТ БИЧГҮҮД

ФАТФ-ын 24 дүгээр зөвлөмж, 2020 оны 10 дугаар сар, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/recommendations/pdfs/FATF%20Recommendations%202012.pdf>.

Хуулийн этгээдийн эцсийн өмчлөгчийн талаар сайн туршлагауд, ФАТФ, 2019 оны 10 дугаар сар, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/Best-Practices-Beneficial-Ownership-Legal-Persons.pdf>

Монгол улсад хийгдсэн Харилцан үнэлгээний тайлан, 2017 оны 9 дүгээр сар, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/mer-fsrb/Mongolia%20MER%202017%20-%20published%20version.pdf>

Монгол улсад хийгдсэн Харилцан үнэлгээний 2 дугаар тайлан, 2019 оны 10 дугаар сар, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-Follow-Up-Report-Mongolia-2019.pdf>

Дахин үнэлгээний 3 дугаар тайлан, Монгол улсад хийгдсэн Харилцан үнэлгээ, 2020 оны 8 дугаар сар, <https://www.fatf-gafi.org/media/fatf/documents/reports/fur/APG-3rd-Follow-Up%20Report-Mongolia-2020.pdf>.

## ЭЦСИЙН ӨМЧЛӨГЧИЙН ЧИГЛЭЛЭЭР ГАРСАН БУСАД БАРИМТ БИЧГҮҮД

Байгалийн баялгийн нэмүү өртгийн сүлжээн дэх авлигатай тэмцэх TAP-Plus (Ил тод байдал, эгэх хариуцлага, оролцоо+) хандлага, “Авлигыг бууруулахад ил тод байдлыг хангах” төсөл (LTRC), 2020 оны 6 дугаар сар

Эцсийн өмчлөгчийн дэлхий нийтийн хэм хэмжээ (Towards a Global Norm of Beneficial Ownership), 2019 оны 3 сар, <https://adamsmithinternational.com/reports/towards-a-global-norm-of-beneficial-ownership-transparency/>.

Азербайжан улсад эцсийн өмчлөгчийг ил тод болгох чиглэлээр АХБ-ны санхүүжилтээр хэрэгжиж буй төслийн тайлангууд, <http://hssk.gov.az/en/ownership>

Гана улсын эцсийн өмчлөгчийн мэдээлэл цуглуулах маягт, <https://rgd.gov.gh/forms.html>



МОНГОЛ УЛС ДАХЬ ЭЦСИЙН  
ӨМЧЛӨГЧИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ:  
ЦААШДЫН ЧИГЛЭЛ

# Англи хэлнээс орчуулав

---

**LTRC**

Leveraging Transparency to Reduce Corruption